



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



From
the People of Japan



Save the Children

“НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХЭД ЧИГЛЭСЭН СУРГУУЛИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ХАРААТ БУС СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН ТББ-ААС ЯПОНЫ ХҮҮХДИЙГ
ИВЭЭХ САНД ЗОРИУЛАН БОЛОВСРУУЛЛАА.

УЛААНБААТАР
2018

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Дүрсийн жагсаалт.....	3
1. Ерөнхий хураангуй.....	4
2. Төслийн танилцуулга	7
3. Үнэлгээний дизайн.....	8
3.1. Үнэлгээний зорилго	8
3.2. Үнэлгээний дизайн	8
3.3. Мэдээлэл цуглуулалтын аргууд	9
3.4. Түүврийн хэмжээ	10
3.5. Үнэлгээний хязгаарлагдмал тал	11
4. Үнэлгээний үр дүн.....	12
4.1. Багш	12
4.2. Сургуулийн дэмжих бүтэц, тогтолцоо.....	21
4.3. Эцэг эхчүүд.....	31
4.4. Нөлөөлөл.....	39
4.5. Бусад.....	43
5. Дүгнэлт.....	50
5.1. Багш нар	50
5.2. Сургуулийн дэмжих бүтэц тогтолцоо.....	51
5.3. Эцэг эхчүүд.....	52
5.4. Нөлөөлөл.....	53
6. Санал зөвлөмжүүд.....	54
6.1. Багш	54
6.2. Сургуулийн удирдлага	54
6.3. Эцэг эх.....	55
6.4. Нөлөөлөл.....	56

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Мэдээлэл цуглуулалтын арга	9
Хүснэгт 2. Түүврийн хэмжээ	11
Хүснэгт 3. Зорилтот сургуулиудад хүүхдийн мэдээллийг ашиглах байдал (%)	17
Хүснэгт 4. Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах чиглэлээр хийгдсэн үйл ажиллагаанууд	18
Хүснэгт 5. Хүүхдийн хувийн мэдээллийг баримтжуулалт (%)	19
Хүснэгт 6. “Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах арга зүй” модулийн хэрэгжилтийн өмнө болон дараах байдал	20
Хүснэгт 7. БЗД-ийн 79-р сургуулийн дотоод дүрэм, журмын өөрчлөлт	22
Хүснэгт 8. Нэгдүгээр ангид элсэж буй сурагчдыг хүлээн авах бэлтгэл ажил дах сургуулийн дэмжлэг (%).....	23
Хүснэгт 9. Сургалтын орчны шинэчлэл	24
Хүснэгт 10. Бага ангийн багшийн үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт.....	26
Хүснэгт 11. Сургуулийн ажилтнуудын оролцооны жишээнээс.....	26
Хүснэгт 12. Хамтрагч байгууллагуудын оролцоо	29
Хүснэгт 13. Төслийн хэрэгжилтийн үйл явцад судалгаанд оролцогчдын гаргасан санал бодлууд.....	29
Хүснэгт 14. Төслийн нөлөөллийн үйл ажиллагаанд нийгмийн сүлжээг ашигласан байдал.....	42

Дүрсийн жагсаалт

Дүрс 1. Туршилтын бус загвар	8
Дүрс 2. Суралцах чадварын талаарх мэдлэг, үр чадвараа ‘эерэг’ (маш сайн, сайн) гэж үнэлсэн багш нарын хувь (%).....	13
Дүрс 3. Сурагчдын үр чадварыг эерэгээр үнэлсэн хувь (%).....	14
Дүрс 4. Суралцах чадварын талаарх мэдлэг, ойлголтын үр дүнд нөлөөлөгч хүчин зүйлс.....	15
Дүрс 5. Сурагчийн хувийн мэдээллийг цуглуулах байдал (%)	16
Дүрс 6. Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах арга зүй модуль сургалтын үр дүн (%).....	17
Дүрс 7. Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах аргачлалын цикл	19
Дүрс 8. Нэгдүгээр ангийн сурагчдыг дэмжих сургуулийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд...	21
Дүрс 9. Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд	22
Дүрс 10. Эцэг эхтэй харилцаж буй арга хэрэгслүүд	28
Дүрс 11. Эцэг эхчүүдэд чиглэсэн үйл ажиллагаа, оролцооны хувь (%).....	31
Дүрс 12. Эцэг эхийн багштай харилцан ярилцдаг асуудлууд (%)	33
Дүрс 13. Эцэг эхчүүдийн багшаас авдаг мэдээлэл (“Тийм” гэж хариулсан хувь (%))	33
Дүрс 14. Харилцах дэвтрийн ашиглалтын хувь (%).....	34
Дүрс 15. “Эцэг эх-Багштай харилцах дэвтэр”-н хүүхдийн суралцах болон дасан зохицох чадварт үзүүлсэн дэмжлэг (%)	35
Дүрс 16. Эцэг эхийн зөвлөлийн талаар мэдэж буй эцэг эхийн хувь (%)	36
Дүрс 17. Эцэг эхчүүдийн оролцооны үнэлгээ, 'сайн' гэсэн хариулт өгсөн хувиар (%)	37
Дүрс 18. Төслийн хамтын ажиллагаа /хэрэгжилтийн үе шатаар/	41

1. Ерөнхий хураангуй

Японы Хүүхдийг Ивээх Сан (ЯХИС), Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам (БСШУСЯ)-тай хамтран Японы Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхийг бэхжүүлэх нь” (2015-2018) төслийг хэрэгжүүлсэн. Уг төсөлд Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын 24 сургуулийг 3 үе шаттайгаар хамруулжээ. Уг төсөл нь “Сургуульд дасан зохицох хөтөлбөр”-ийн тусламжтайгаар сонгосон төрийн өмчийн сургуулиудын 1-р ангийн сурагчдын суралцах чадварыг дээшлүүлэх зорилготой юм. Уг зорилгын хүрээнд төсөл нь сургуулийн удирдлага, багш, эцэг эхэд болон бодлогын түвшинд чиглэсэн дөрвөн зорилт тавьж ажилласан.

Төслийн үр дүнд бий болсон өөрчлөлтийг төслийн баримт бичигт дурдсан төслийн 4 зорилтын хүрээнд тавьсан 8 шалгуур үзүүлэлтийн үр дүн болон бусад тоон болон чанарын судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэлээ.

Төслийн үр дүнг үр дүнгийн үзүүлэлт тус бүрээр дараах хүснэгтэд хураангуйлан харуулав.

Үр дүнгийн үзүүлэлтүүд		Зорилтот үзүүлэлт	Эцсийн үнэлгээ
Зорилт 1	Үр дүнгийн үзүүлэлт 1.1.1: Төсөлд хамрагдах сургуулийн анги даасан багш нарын 80% нь хүүхдийн суралцах чадварын талаарх арга зүйн мэдлэг, ойлголт сайжирч, зорилтот бус сургуулийн багш нарт түгээх боломжтой болсон байна.	80%	91.4%
	Үр дүнгийн үзүүлэлт 1.1.2: Зорилтот сургуулийн багш нарын 80% нь сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг сайжирсан гэж үнэлсэн байна.	80%	85.1%
	Үр дүнгийн үзүүлэлт 1.2: Төсөлд хамрагдах сургуулийн анги даасан багш нарын 80% нь хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хянах, ашиглах арга зүй эзэмшсэн байна.	80%	89.8%
Зорилт 2	Үр дүнгийн үзүүлэлт 2.1: Бүх зорилтот сургуулиудад “Бэлтгэл хөтөлбөр”-ийг хөгжүүлж, өөрийн үнэлгээний тогтолцоог бий болох, үр дүн туршлагаа зорилтот бус сургуулиудад түгээх чадвартай болсон байна.	Бүх (24)	Бүх (24)
	Үр дүнгийн үзүүлэлт 2.2: Бүх зорилтот сургуулиудад “Сургуулийн бэлтгэл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутгийн төрийн байгууллагуудтай тогтвортой хамтын ажиллагааны механизм бүрдүүлсэн байна.	Бүх (24)	Бүх (24)
Зорилт 3	Үр дүнгийн үзүүлэлт 3.1: Зорилтот сургуулийн эцэг эхийн 80% нь олон хэлбэрээр багш нартай тогтмол харилцаж, зорилтот бус сургуулиудад туршлагаа түгээдэг байна.	80%	90.7%
	Үр дүнгийн үзүүлэлт 3.2: Бүх зорилтот сургууль сургуулийн ажилтнууд болон эцэг эхчүүдийн дэмжлэг бүхий идэвхтэй эцэг эхийн зөвлөлтэй болж, өөрсдийн туршлагыг зорилтот бус сургуулиудад түгээдэг байна.	Бүх (24)	Бүх (24)
Зорилт 4	Үр дүнгийн үзүүлэлт 4.1: Төслийн удирдах зөвлөлийн 12 гишүүн байгууллагуудаас хамгийн багадаа 6 байгууллага нь (БСШУСЯ, БМДИ, МУБИС, Нийслэл, 3 дүүргийн боловсролын хэлтэс зэрэг) өөрийн үйл ажиллагаагаа төслийн үйл ажиллагаатай холбон ажилласан байна.	6	6

Төслийн эцсийн үнэлгээний үр дүнгээс харахад төслийн 4 зорилтын хүрээнд тавьсан 8 шалгуур үзүүлэлт бүгд зорилтот үзүүлэлтдээ хүрчээ. Энэ нь төслийн “Төсөл хэрэгжих зорилтот дүүргийн төрийн өмчийн сургуулиудын нэгдүгээр ангийн сурагчдын “суралцах чадвар”-ыг дээшлүүлэх” зорилго бүрэн биелсэн гэж дүгнэх үндэс болж байна. Дээрх зорилтуудын биелэлтийг дараах үр дүнгүүд батлан харуулж байна.

Багш нарын түвшинд, төслийн зорилтот сургуулийн багш нарын хүүхдийн суралцах чадварын талаарх мэдлэг модулийн сургалтын дараа мэдэгдэхүйц нэмэгджээ. Мөн төслийн хүрээнд нэвтрүүлсэн 5 модулийн үр дүнд багш нар хүүхдийн дасан зохицох, суралцах чадварыг ажлыг сургалт болон сургалтын бус ажлаар дамжуулан нэмэгдүүлэх олон арга зүй, аргачлалыг суралцаж, түүнийгээ ашигладаг дадал, туршлагатай болсон байна. Мөн багш дан ганц сургалтын үйл ажиллагаанд анхаарах бус, эцэг эх, бусад ажилтнууд, хороо, цэцэрлэг, өрхийн эмнэлэгтэй хамтран сургалтаас гадуурх ажлаар дамжуулан сурагчдын суралцах чадварыг хөгжүүлэх мэдлэг, туршлагатай болжээ.

Сургуулийн дэмжих бүтэц тогтолцооны хувьд, төслийн зорилтот сургуулиудад “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр”-г хэрэгжүүлснээр сургуулийн удирдлага эцэг эх, орон нутгийн хороо, эмнэлэг гэх мэт олон талуудын нэгдүгээр ангийн сурагчдын сурагчдын суралцах чадварыг нэмэгдүүлэх ойлголт мэдлэг нэмэгдэхээс гадна энэ чиглэлийн хамтын ажиллагаа идэвхжсэн. Тухайлбал, хороо, цэцэрлэг, өрхийн эмнэлэгүүдээс сурагчдын талаар мэдээлэл авах, хамтарсан сургалт хийх, сургуультай танилцах аяллыг зохион байгуулах, нэгдүгээр ангийн сурагчдад ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлд хамтран ажилладаг сайн туршлагуудыг бий болжээ. Сургуулийн хөтөлбөр, жилийн төлөвлөгөө, сургуулийн дүрэм, журам болон багш, ажилтнуудын хөдөлмөрийн гэрээ болон ажлын байрны тодорхойлолтод нэгдүгээр ангийн сурагчдыг дэмжихтэй холбоотой зүйл, заалтуудыг тусгаж өгсөн. Мөн сургуулийн гадна болон дотоод орчинд үнэлгээ хийн сургалтын орчныг сайжруулах, сургуулийн анги танхимын тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах, сургалтын орчны зураглал гаргах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн нь эрүүл, аюулгүй орчинд суралцах нөхцөлийг сайжруулсан байна. Дээрх олон санал санаачилгууд нь сургуулийн дэмжих бүтэц тогтолцоонд ихээхэн эерэг өөрчлөлтийг авчирчээ.

Эцэг эхчүүдийн түвшинд “Сургууль-Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй”, “Эцэг эх-Багштай харилцах дэвтэр”-тэй ажиллах арга зүй гэсэн сургалтын модулиудыг боловсруулж, хэрэгжүүлсэн. “Эцэг эх-Багштай харилцах дэвтэр”-тэй ажиллах арга зүй сургалтын модулийн үр дүнд эцэг эхийн оролцоо нь гэр, анги, сургуулийн орчинд хүүхдийн засан зохицох, суралцах чадварыг хөгжүүлэх боломжийг олгохоос гадна, багш нарын сургалтын чанар, хэрэглэгдэхүүний хүртээмж сайжрах зэрэг олон эерэг өөрчлөлт бий болгосон байна. “Сургууль-Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй” сургалтын модулийн үр дүнд эцэг эхийн зөвлөл үйл ажиллагаандаа шинэ аргачлал, арга зүйг нэвтрүүлснээр үйл ажиллагаа нь илүү зохион байгуулалттай болж, шинэ төрлийн үйл ажиллагаа санаачлан хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Үүний үр дүнд эцэг эхийн оролцоо сайжирч, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг болсноор багш нарын ачаалал багасч, хүүхдэд ээлтэй анги танхим, орчин бүрдүүлэх, шинэлэг сургалтын аргачлал, хэрэглэгдэхүүн ашиглах зэргээр хүүхдийн суралцах чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Нөлөөллийн ажлын үр дүнд 2015 онд БСШУСЯ-тай Харилцан ойлголцлын санамж бичиг зурсан. Мөн төслийн бодлогын түвшинд арга зүйгээр хангах, боловсролын салбарын гол оролцогч талуудын дунд нягт хамтын ажиллагааг бий болгох зорилго бүхий 100 орчим гишүүнтэй Ажлын хэсэг, 12 байгууллага нэгдсэн Төслийн Удирдах Зөвлөлийг байгуулсан. Энэхүү дүүргийн болон үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулж буй талууд хамрагдсан нь төслийн

амжилттай туршлага, сайн аргачлалыг бусад дүүрэг, орон нутгийн зорилтот бус сургуулиудад нэвтрүүлэх боломжийг бий болгох юм. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Тухайлбал БСШУСЯ-ны сурах бичгийн нэгдсэн жагсаалтад “Бэлтгэл хөтөлбөр”-ийг оруулсан “Хүүхдийн хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах арга зүй” сургалтын модулийн зарим асуултуудыг Боловсролын Удирдлага мэдээллийн санд оруулсан зэрэг ололттой ажлууд хийгджээ.

Дээр дурдагдсан бүхий л түвшний олон талуудыг хамруулсан, өргөн цар хүрээ бүхий шинэ санал санаачилгууд нь нэгдүгээр ангийн хүүхдийн сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дээшлүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулжээ. Тиймээс, төслийн хүрээнд бий болсон сайн туршлага, санаачилгууд нь хамтран ажилласан, төсөлд хамрагдсан олон талуудаар дамжин цаашид өргөжих шаардлага бий болж байна.

2. Төслийн танилцуулга

Японы Хүүхдийг Ивээх Сан (ЯХИС), Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам (БСШУСЯ)-тай хамтран Японы Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхийг бэхжүүлэх нь” төслийг 2015 оны 3-р сараас 2018 оны 3-р сарын хооронд хэрэгжүүлж байна. Уг төсөлд Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн нийт 24 сургуулийг 2 үе шаттайгаар сонгон авч хамруулсан.

Төслийн зорилго нь “Сургуульд дасан зохицох хөтөлбөр”-ийн тусламжтайгаар сонгосон төрийн өмчийн сургуулиудын 1-р ангийн сурагчдын суралцах чадварыг дээшлүүлэх юм. Энэхүү зорилгын хүрээнд сургуулийн удирдлага, багш, эцэг эх болон төрийн бодлогын 4 гол түвшинд үйл ажиллагаа явуулж байна.

Уг зорилгын хүрээнд дараах дэд зорилтуудыг дэвшүүлэн ажилласан.

1. Хүүхдийн суралцах чадварыг хангах талаар зорилтот сургуулийн бага ангийн багш нарын мэдлэг, ойлголт, чадварыг сургалтад хамруулах замаар дээшлүүлэх,
2. Зорилтот сургуулиудад нэгдүгээр ангийн хүүхдийн суралцах чадварыг дэмжих ялангуяа сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдэд сургуульд дасан зохицох, суралцах чадвар эзэмшихэд туслах бүтэц, тогтолцоо бүрдүүлэх,
3. Хүүхдийн суралцах чадварыг дэмжих талаар эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлууд зохион байгуулах,
4. Төслийн үр дүнд амжилттай хэрэгжсэн загвар, үйл ажиллагааг сурталчлах, төрийн бодлогод тусгах.

Энэхүү төсөл нь Улаанбаатар хотын захын шилжин суурьшсан өрхийн болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдалгүйгээр сургуульд элсэн орж буй хүүхдийн тоо хамгийн ихтэй 3 дүүргийн 5-6 настай хүүхдүүдэд чиглэсэн болно. Ялангуяа, зорилтот гурван дүүргийн 59 сургуулиас сонгогдсон зорилтот 24 сургуульд элсэх гэж буй болон элссэн сурагчдад чиглэсэн.

Төслийг эхний жил 12 сургуульд, 2 дах жилд 12 сургууль нэмж сонгон нийт 24 сургуулийг төслийн зорилтот сургуулиар сонгож, төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Төслийн сүүлийн жилд эхний хоёр жилийн төслийн үр дүнд цуглуулсан нотолгоонд тулгуурлан бодлогын нөлөөллийн ажилд түлхүү анхаарч ажилласан.

Төслийн гурав дах шатанд төсөлд хамрагдаагүй үлдсэн 35 сургуультай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, энэхүү төслийнхөө үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлснээр зорилтот гурван дүүргийнхээ төрийн өмчит бүх сургуулийг хамруулсан.

3. Үнэлгээний дизайн

3.1. Үнэлгээний зорилго

Энэхүү үнэлгээний ерөнхий зорилго нь нотолгоонд суурилсан аргачлалаар төслийн үр дүн, хэрэгжилтийн явцыг үнэлж, дүн шинжилгээ хийхэд оршиж байв.

Дээрх зорилгын хүрээнд дараах дэд зориултуудыг дэвшүүлэн ажилласан.

1. Төсөл нь урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт тус бүрээр хүрэхээр төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэх болон хүрсэн түвшинг тодорхойлох,
2. Төслийн үр дүнд зорилтот сургуулиудад бий болсон нэгдүгээр ангийн хүүхдийн сургуульд дасан зохицох, суралцах чадвар эзэмшихэд туслах бүтэц, тогтолцооны тогтвортой байдлыг тодорхойлох, ингэхдээ сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан болон хамрагдаагүй, мөн гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн ялгааг тодорхойлох,
3. Зорилтот сургуулиудын бага ангийн багш нар болон бусад ажилтнуудын хүүхдийн хөгжил, сургуульд бэлтгэгдсэн байдал, дасан зохицох чадварын талаарх мэдлэг, ойлголт, чадавхийн түвшинг зорилтот бус сургуулиудтай харьцуулах замаар үнэлэх,
4. Сургуульд бэлтгэгдсэн байдал болон дасан зохицох чадварын талаарх эцэг эх, асран хамгаалагчдын ойлголт, оролцоонд бий болсон өөрчлөлтийг төсөл хэрэгжихээс өмнө, дараах байдлаар харьцуулан тодорхойлох,
5. Сургуульд бэлтгэгдсэн байдал болон дасах зохицох чадварыг хөгжүүлэх чиглэлээр төслийн хүрээнд хамгийн амжилттай хэрэгжсэн, цаашид тогтвортой хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагаа, туршлагуудыг тодорхойлох,
6. Төслийн хүрээнд бий болсон сургамж, сайн туршлагууд, үр нөлөөнд үндэслэн гол оролцогч талууд болон зорилтот ба зорилтот бус сургуулиудад зориулан зөвлөмж боловсруулах.

3.2. Үнэлгээний дизайн

Судалгааны ерөнхий загвар нь 'туршилтын бус' ('non-experimental') загвар бөгөөд үүнийг доорх дүрсэд харууллаа.



A_1 – Суурь судалгаа, A_2 – Эцсийн үнэлгээний судалгаа, X_1 – Өөрчлөлтүүд

Туршилтын бус дизайн гэдгээс үл хамааран, төслийн үр дүн, үр нөлөөг бодитой үнэлэх зорилгоор зорилтот бус бүлгийг үнэлгээнд хамруулсан.

2015 оны 4 сард хийсэн суурь судалгаатай адилаар 2017 онд хийсэн энэхүү үнэлгээний судалгаа нь доорх зүйлс дээрх хооронд нь харьцуулах, үр дүнгүүдийг нь хэмжин үнэлэхүйц байх шаардлагатай байв:

- **Үнэлгээний судалгаанууд:** Суурь судалгааны гол үзүүлэлтүүдийг эцсийн үнэлгээний судалгааны үр дүнтэй харьцуулах боломжтой байх ёстой. Тиймээс төслийн үр нөлөөг

илэрхийлэх, мэдлэг, хандлага, дадалтай холбоотой гол үзүүлэлтүүдийг эцсийн үнэлгээний судалгаанд давтан асууж, үр дүнг харьцуулан үнэлсэн.

- **Байршил:** Сонгон авсан сургуулиудын судалгааны үр дүнг харилцан бие биетэй нь харьцуулах боломжтой байх ёстой. Өөрөөр хэлбэл сургууль сонголт болон түүвэрлэлт нь статистикийн хувьд хангалттай, өгөгдсөн сургуулиудыг бүрэн төлөөлж байх ёстой. Тиймээс, суурь судалгаанд хамруулсан бүх сургуулиудыг эцсийн үнэлгээний судалгаанд хамруулсан.

3.3. Мэдээлэл цуглуулалтын аргууд

Судалгааны мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан цуглуулсан. Мэдээлэл цуглуулалтын арга тус бүрийн агуулга, зорилтот бүлгийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 1. Мэдээлэл цуглуулалтын арга

	Арга	Судалгаанд оролцогчид	Агуулга
Тоон судалгаа	Асуумж	Багш нар (Зорилтот ¹ болон Зорилтот бус ² сургууль)	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн суралцах чадварын талаарх мэдээлэл • Хүүхдийн хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах • Эцэг эхийн хамтын ажиллагаа, оролцоо • Сургуулийн зүгээс багшид үзүүлж буй дэмжлэг • Багшийн заах арга зүй, арга барил
		Эцэг эх (Зорилтот болон Зорилтот бус сургууль)	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн суралцах чадвар • Эцэг эхчүүдийн ойлголт, мэдлэг, чадвар • Эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагаа
Чанарын судалгаа	Ганцаарчилсан ярилцлага	БСШУСЯ Дүүргийн Боловсролын Хэлтсийн мэргэжилтэн Сургуулийн захирал/менежер Эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл	<ul style="list-style-type: none"> • Төслийн хамааралтай байдал • Төслийн үр нөлөө • Төслийн хүрээнд бий болсон хамтын ажиллагаа • Төслийн тогтвортой байдал
	Фокус бүлгийн ярилцлага (ФБЯ)	Багш нар (Зорилтот сургууль)	
	Кейс судалгаа	Эцэг эх (Зорилтот сургууль)	<ul style="list-style-type: none"> • Төслийн үр нөлөө

Тоон аргуудыг төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд шаардлагатай тоон үзүүлэлтийг гарган авахад ашигласан. Мөн төслийн үр дүнд эцэг, багш нарын мэдлэг, хандлага, дадалд гарсан өөрчлөлтийг үнэлэхэд тоон судалгааны үр дүнг ашигласан. Харин чанарын судалгааны мэдээллийг гол төлөв төслийн хамааралтай байдал болон төслийн үр дүнд бий болсон хамтын ажиллагаа, өөрчлөлт, үр нөлөөг тодорхойлоход ашигласан. Мөн төслийн үр дүнд бий болсон сайн туршлагуудыг илрүүлэх, төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг тодорхойлоход чанарын мэдээлэл гол эх сурвалж болсон.

¹Төсөлд хамрагдсан сургууль

²Төсөлд хамрагдаагүй сургууль

3.4. Түүврийн хэмжээ


Эцсийн үнэлгээнд төслийн дизайн болон зорилготой уялдуулан олон шатлалт түүврийн аргыг ашигласан. Нэгдүгээрт, үнэлгээний мэдээллийг цуглуулах сургуулиудыг сонгон авсан. Үүний дараа, судалгаанд оролцогчийн бүлгийг тодорхойлж, тэдгээр бүлгээс түүвэрлэлт хийсэн.

- **Сургууль сонголт**

“Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхийг бэхжүүлэх нь” төсөл Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 24 сургуульд хэрэгжсэн. Эцсийн үнэлгээнд 3 дүүргийн **зорилтот буюу** төсөл хэрэгжсэн бүх 24 сургууль болон **зорилтот бүс** буюу төсөл хэрэгжээгүй 10 сургуулийн 1-5-р ангийн сурагчдын эцэг эх, багш нарыг хамруулсан.

- **Судалгаанд оролцогчдын бүлгийг тодорхойлох**

Үнэлгээний баг 1-5-р ангийн сурагчдыг төслийн эцсийн үр шим хүртэгчид гэж тодорхойлж байгаа. Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг нэмэгдүүлэхэд төрийн бодлого, сургуулийн удирдлагын оролцоо мэдээж чухал нөлөөтэй. Гэхдээ хүүхдүүдтэй шууд харилцдаг хамгийн гол нөлөөтэй хүмүүс нь багш нар болон эцэг эхчүүд болно. Төгсгөлийн үнэлгээний судалгаанд сурагчдыг өөрсдийг нь хамруулалгүй, эцэг эх болон багш нарыг нь хамруулж, тэднээр дамжуулан сурах чадварт нь гарч буй өөрчлөлтийг үнэлүүлэх аргачлалыг ашигласан. Энэхүү үнэлгээний дизайн нь сурагчдын мэдлэг, хандлага, дадалд гарч буй өөрчлөлтийг эцэг эх болон багш нарын санал бодолд тулгуурлан үнэлэх боломжийг олгож байгаа юм.



Үнэлгээнд хамруулах эцэг эх болон багш нарын түүврийг тоог зорилтот 3 дүүргийн төрийн өмчийн сургуулийн 1- 5-р ангийн багш нар болон эцэг эхчүүдийн тоонд суурилан тодорхойлов.

$$n = \frac{Z^2 * p * (1-p)}{C^2}$$

Энд,

Z-стандарт хэвийн тархалтын утга (95 % итгэх түвшинтэй үед 1.96 байна),
p-тухайн хувилбарын сонгогдох магадлал (түүврийн хэмжээг олохдоо 0.5 гэж авна),
C - итгэх завсар, (бид 0.05 буюу ±5%).

Параметруудийг дээрх утгатайгаар сонгосон.

Зорилтот 3 дүүргийн 1-5-р ангийн багш нарын тоо-1757, Төлөөлөх чадвартай түүврийн хэмжээ~315

Зорилтот 3 дүүргийн 1-5-р ангийн сурагчдын эцэг эхчүүдийн тоо-ойролцоогоор 53446), төлөөлөх чадвартай түүврийн хэмжээ нь ~381.

Судалгааны төлөөлөх чадварыг хангалттай байлгах, мэдээллийн чанараас үүдэн асуумжийн тоо багасах зэрэг эрсдэлээс сэргийлж түүврийн хэмжээг нэмсэн. Эцсийн үнэлгээний тоон болон чанарын судалгааны түүврийн хэмжээг дараах хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 2. Түүврийн хэмжээ

Дүүрэг	Асуумж				Ганцаарчилсан ярилцлага		ФБЯ	Кейс судалгаа
	Багш нар		Эцэг эхчүүд		Сургалтын менежер	Эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл		
	Зорилтот	Зорилтот бус	Зорилтот	Зорилтот бус				
Чингэлтэй	122	39	118	41	6	5	1 (13 багш)	4
Баянзүрх	126	53	118	57	8	5	1 (10 багш)	4
Сонгинохайрхан	124	40	121	45	8	2	1 (9 багш)	2
НИЙТ	372	132	357	143	22	12	3 (32 багш)	10

Үнэлгээнд нийт 504 багш, 500 эцэг эхийг хамруулсан. Мөн түүнчлэн 3 фокус бүлгийн ярилцлага, 38 ганцаарчилсан ярилцлага болон 10 кейс судалгааны мэдээлэл цуглуулсан.

3.5. Үнэлгээний хязгаарлагдмал тал

- Суурь судалгааг хичээлийн жилийн эцэст авсан бол төгсгөлийн үнэлгээний судалгааг хичээлийн жилийн хагаст авч байна. Хүүхдийн мэдлэг чадварыг багш нараар хичээлийн жилийн өөр цаг үеүүдэд үнэлүүлж байгаа учраас бодитой үнэлэх боломжийг хязгаарлаж байна.
- Төсөлд хамрагдсан сургуулиудын нөхцөл байдал нь сонгогдсон тухайн сургуулиудын нөхцөл байдлыг л харуулна. Сургууль бүрийн онцлогоос хамаарч давуу болон сул талууд байж болох бөгөөд энэ нь төслийн үр дүнг дөвийлгөх эсвэл төслийн үр дүнг бууруулж харуулж байж болзошгүй.
- Төсөлд хамрагдаагүй сургуулиудын нөхцөл байдал нь тухайн сургуулийн онцлогоос хамаарч, тухайн дүүрэг байршлын онцлогоос хамаарч тухайн сургуулиудын нөхцөл байдлыг л харуулна. Тиймээс төсөл хэрэгжээгүй бусад сургуулиудыг бүрэн төлөөлж чадахгүй.
- Суурь судалгааны үеэр төслийн баримт бичиг болон төслийн үр дүнг үнэлэх индикаторууд тодорхой бус байсан. Тиймээс одоогийн ашиглаж буй зарим шалгуур үзүүлэлтүүдийн суурь түвшинг тодорхойлох боломжгүй байна.
- Суурь судалгаанд цөөн тооны (n=100) багш нарыг хамруулсан. Энэ нь эцсийн үнэлгээнд хамрагдсан багш нарын судалгааны үр дүнтэй харьцуулсан шинжилгээ хийх боломжийг хязгаарлаж байна. Тиймээс, багш нарын асуумжийн үр дүнг зорилтот болон зорилтот бус сургуулийн багш нар хоорондын үр дүнгээр харьцуулах нь илүү оновчтой. Мөн багш нарт үзүүлж буй үр нөлөөг зорилтот сургуулийн багш нартай хийсэн чанарын судалгаанд суурилах нь илүү бодитой үнэлгээ болно.

4. Үнэлгээний үр дүн

4.1. Багш

Энэхүү дэд бүлэгт төслийн Зорилт 1 буюу 'Хүүхдийн суралцах чадварыг хангах талаар зорилтот сургуулийн бага ангийн багш нарын мэдлэг, ойлголт чадварыг сургалтад хамруулах замаар дээшлүүлэх' ажлын хүрээнд бий болсон үр дүнг танилцуулна.

Төслийн үр дүнг үнэлэх зорилгоор Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн төслийн зорилтот болон зорилтот бус сургуулиудын 504 багшийг үнэлгээнд хамруулсан. Нийт багш нарын 73.8 хувь нь зорилтот сургуулийн багш нар, 26.2 хувь нь зорилтот бус сургуулийн багш нар байлаа. Үнэлгээнд хамрагдсан багш нарын олонхи нь бакалавр зэрэгтэй байна. Мөн судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь заах аргач болон тэргүүлэх зэрэгтэй багш нар байна. Багш нарын хувьд дунджаар 13-14 жилийн туршлагатай багш нар байна. Эдгээр үзүүлэлтүүд нь суурь судалгаанд оролцсон багш нарын шинж байдалтай ойролцоо байна. Үнэлгээнд хамрагдсан багш нар дунджаар 37 хүүхэдтэй анги удирдаж байгаа бөгөөд үүнээс 19 нь эрэгтэй, 19 эрэгтэй хүүхэдтэй ангиуд байна. Мөн дундаж үзүүлэлтээр харвал, 29 нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан 8 нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдүүд байна.

Төслийн багш нарт үзүүлсэн үр дүнг төслийн баримт бичигт дурдсан гурван үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлжээ.

Үр дүнгийн үзүүлэлт 1.1.1

Үр дүнгийн үзүүлэлт 1.1.1: Төсөлд хамрагдах сургуулийн анги даасан багш нарын 80% нь хүүхдийн суралцах чадварын талаарх арга зүйн мэдлэг, ойлголт сайжирч, зорилтот бус сургуулийн багш нарт түгээх боломжтой болсон байна.


Эцсийн үнэлгээний үзүүлэлт: 91.4%

Мэдээллийн эх сурвалж: Багш нарын асуумж, Багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлага

Гол үр дүн

Зорилтот сургуулийн багш нарын хүүхдийн суралцах чадварын талаарх мэдлэг, чадвар мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Тухайлбал, зорилтот сургуулийн багш нарын **91.4 хувь** нь өөрсдийн суралцах чадварын талаарх арга зүйн мэдлэг, ойлголтоо эерэгээр (маш сайн ба сайн) үнэлсэн байна. Зорилтот сургуулийн багш нар сурагчдын дасан зохицох чадвар болон суралцах чадварын мэдлэг, чадвараа эерэгээр үнэлсэн хувь модуль сургалтын дараа 55.2 хувиар нэмэгдсэн бол, зорилтот бус сургуулийн багш нарынх 29.7 хувиар нэмэгджээ.

Дүрс 2. Суралцах чадварын талаарх мэдлэг, үр чадвараа ‘эерэг’ (маш сайн, сайн) гэж үнэлсэн багш нарын хувь (%)



Төслийн хүрээнд дүүргийн хэмжээнд зорилтот болон зорилтот бус сургуулиудын хооронд туршлага солилцох талаар арга хэмжээг зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээний хүрээнд зорилтот сургуулийн багш нар зорилтот бус сургуулийн багш нарт өөрсдийн мэдлэг, чадвараа түгээх ажил хийсэн. Мөн төслийн бүх зорилтот сургуулиуд өөрсдийн тойргийн зорилтот бус сургуулиудыг хариуцан, өөрсдийн мэдлэг, туршлага хуваалцан ажилласан нь сургуулийн удирдлагуудтай хийсэн ярилцлагын үр дүнгээс харагдаж байлаа. Тухайлбал, зорилтот сургуулиудаас зорилтот бус сургуулиудад зориулан модуль сургалтуудыг зохион байгуулах, арга, аргачлал танилцуулах өдөрлөг зохион байгуулах, сургуулийн удирдлага, багш, эцэг эхийн төлөөллийн хамтарсан туршлага солилцох уулзалтууд хийх гэх мэт олон хэлбэрээр, олон талуудыг хамруулж өөрсдийн мэдлэг, чадварыг туршлага түгээж байна.

Манай сургууль өөрийн тойргийн 12, 62-р сургуулиудад туршлагаа түгээн дэлгэрүүлж байна. Эхний ээлжинд 5 модуль сургалтаа зохион байгуулж, сургалтын хүрээнд заасан арга аргачлалаа сургууль дээр хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавин ажиллаж байгаа. Мөн сургуулиудын 1-р ангийн багш хоорондын уулзалт зохион байгуулжээ.

УБ. Сонгинохайрхан дүүрэг. Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас

Тиймээс төслийн хүрээнд зорилтот сургуулиуд болон зорилтот бус сургуулийн багш нар туршлага хуримтлуулж өөрийн мэдлэг, чадвараа бусдад **түгээх мэдлэг**, чадвартай болсон гэж үзэж болохоор байна.

Бусад үр дүн

Багш нарын хүүхдийн суралцах чадварын талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн “Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй” модулийг зорилтот сургуулийн багш нарын 95.1 хувь нь цаашид тогтвортой хэрэгжих боломжтой гэж хариулжээ.

Модульд өгсөн аргачлал, зөвлөмж оновчтой байсан. Сургалтууд нь сургалтад сууж байгаа хүний оролцоог бүрэн хангаж чаддаг. Сургалтууд нь дандаа дадлага ажилтай, маш үр дүнтэй, бүтээлч байдалтай сургалтууд байсан. Эргээд бүтээлээ хараад юмаа санадаг байх боломжийг бүрдүүлж өгсөн. Ерөнхийдөө багш нарын арга зүйд маш том өөрчлөлт гарсан. Ялангуяа эцэг эхийг оролцоог сайжруулах, эцэг эхийг сургалтад татан оролцуулах тал дээр манай сургуульд маш том өөрчлөлт ахиц гарсан.

УБ. Сонгинохайрхан дүүрэг. Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас

Сургуулийн удирдлагууд сургалтын модулийн чанар болон агуулга нь сайн байсан учраас багш нарын суралцах чадварын талаарх мэдлэг, үр чадвар сайжрахад эерэг нөлөө үзүүлсэн гэж ярилцлагын үеэр нийтлэг дурдаж байлаа.

Үр дүнгийн үзүүлэлт 1.1.2

Үр дүнгийн үзүүлэлт 1.1.2:

Зорилтот сургуулийн багш нарын 80% нь сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг сайжирсан гэж үнэлсэн байна.

Эцсийн үнэлгээний үзүүлэлт: 85.1%

Мэдээллийн эх сурвалж: Багш нарын асуумж, Багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлага

Гол үр дүн

Дээрх шалгуур үзүүлэлтийн үр дүнгээс харахад, зорилтот сургуулийн багш нарын сурагчдын суралцах чадварыг сайн гэж үнэлсэн хувь **85.1 хувь** буюу суурь судалгаатай харьцуулахад буурсан байна. Үнэлгээний хүрээнд багш нараар ангийнх нь сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-д хамрагдсан болон хамрагдаагүй хүүхдүүдийн суралцах үр чадварыг гол 8 үр чадвараар³ нь харьцуулан үнэлүүлсэн. Сурагчдын үр чадварыг эерэгээр (маш сайн ба сайн) гэж үнэлсэн хувийг нь бусад бүлэгтэй харьцуулан дараах дүрсэд харууллаа.

Дүрс 3. Сурагчдын үр чадварыг эерэгээр үнэлсэн хувь (%)



Дээрх дүрсээс харахад багш нарын сурагчдын дасан зохицох болон суралцах үр чадварыг эерэгээр үнэлж буй хувь суурь судалгаатай харьцуулахад буурчээ. Суурь судалгааны үед багш нар суралцах чадварын ойлголт багатай байсан бөгөөд сурагчдын суралцах чадварыг тодорхойлох, үнэлэх мэдлэг, түршлага дутмаг байсан. Харин эцсийн үнэлгээний үед багш нар төслийн хүрээнд боловсруулсан “Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй” болон “Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах арга зүй” сургалтын модулиудад өгсөн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварын талаарх ойлголт, үр чадварыг дэмжих арга зүй болон сурагчдын суралцах чадварын талаарх мэдээлэл цуглуулах, ахицыг үнэлэх арга зүйд суралцсан. Эдгээр шинэ ойлголт, аргачлал нь багш нарыг сурагчдын суралцах чадварыг бодитой үнэлэхэд хувь нэмэр оруулсан. Тиймээс, багш нарын сурагчдын дасан зохицох болон суралцах чадварыг үнэлж буй байдалд өөрчлөлт орсон байх талтай.

Гэхдээ суурь судалгаатай харьцуулахад СӨБ-д хамрагдаагүй сурагчдын суралцах болон дасан зохицох чадварыг эерэгээр үнэлсэн хувь өссөн байна. Мөн зорилтот сургуулийн багш нар СӨБ-д

³Суралцах чадварыг дараах 8 чадвараар тодорхойлсон. Үүнд: Шинэ зүйл сурахдаа төвлөрөх чадвар, Асуудлыг шийдвэрлэх үр чадвар, Бусадтай хамт суралцах чадвар, Хэл ярианы чадвар, Жижиг булчингийн хөгжил, Эрүүл ахуйн дадал, Аюулгүй байдлын дүрмийг дагах чадвар, Бусадтай харилцах чадвар багтаж байна.

хамрагдсан болон хамрагдаагүй аль аль сурагчдын суралцах чадварыг зорилтот бус сургуультай харьцуулахад өндрөөр үнэлсэн байна.

Бусад үр дүн

Зорилтот сургуулийн багш нар сурагчдынхаа шинэ зүйл сурахдаа төвлөрөх чадвар болон эрүүл ахуйн дадлыг зорилтот бус сургуулийн багш нартай харьцуулахад илүү эерэгээр үнэлсэн байна. Зорилтот сургуулийн СӨБ-д хамрагдсан болон хамрагдаагүй бүх сурагчид энэхүү хоёр үр чадварын хувьд зорилтот бус сургуулийн сурагчдаас мэдэгдэхүйц эерэг үнэлгээтэй байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад, багш нарын сурагчдын суралцах чадварын талаарх ойлголт, мэдлэгийг дадал болгож, практикт нэвтрүүлж, амжилттай хэрэгжүүлэхэд дараах эерэг болон сөрөг хүчин зүйлс нөлөөлж байжээ.

Дүрс 4. Суралцах чадварын талаарх мэдлэг, ойлголтын үр дүнд нөлөөлөгч хүчин зүйлс

Эерэгээр нөлөөлсөн хүчин зүйл	Сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлс
<ul style="list-style-type: none"> •Багш эцэг эхийн чиглэлийг тодорхой болгож өгсөн •Сургууль хооронд туршлага солилцох боломж олгосон •Эцэг эх-Багшийн хамтын ажиллагаа сайжирсан •Эцэг эхчүүд харилцах дэвтрийн тусламжтайгаар хүүхдийн онцлогоо мэддэг болж, хүүхэдтэй ажиллах болсон •Сургуулийн бусад ажилтнуудын хандлага эерэг болсон •Сургуулийн удирдлагуудын хандлага эерэг болсон, дэмжлэг нэмэгдсэн 	<ul style="list-style-type: none"> •Багш нарын ажлын ачаалал нэмэгдсэн •Багш нарын оролцоо, зөвлөгөө өгөх давтамж хэт ойр байсан •Эцэг эх-Багштай харилцах дэвтрийг бөглөх үед багшийн зөвлөгөө өгөх давтамж ойр учраас бүрэн бөглөх боломж хомс •Багш нараас илүү цаг их шаарддаг •Эцэг эхийн хандлага сөрөг, идэвхи оролцоо сул •Хамтран ажиллагчид дэмжлэг үзүүлдэггүй •Багш нарын ажлаас гарах, шилжих хөдөлгөөн их

Төслийн үр дүнд багш нарын суралцах чадварын талаарх арга зүйн мэдлэг, ойлголтыг сургалтаар дамжуулан нэмэгдүүлж, түүнийг нэвтрүүлэх арга зүй, аргачлалыг модулиудад тусгаж өгснөөр практикт ашиглах нөхцөл бүрдсэн. Эдгээр суралцах чадварын талаарх мэдлэг, ойлголтыг багш нар сурагчидтай ажиллахаас гадна эцэг эх, бусад ажилтнууд, сургуулийн удирдлагатай ажиллахад ашиглах юм. Гэвч багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагын үеэр, багш нарын өдөр тутмын ажлын ачаалал их байх, эцэг эх, удирдлага болон хамтран ажиллагчдын дэмжлэг сул зэргээс шалтгаалан сурсан зүйлсийг практикт нэвтрүүлэхэд бэрхшээл учирдаг байна. Мөн түүнчлэн сургуулийн удирдлага болон багш нарын тогтвортой бус байдал нь зорилтот сургуулийн сургагдсан багш нар мэдлэг, ойлголтоо практик хэрэглэх, түгээн дэлгэрүүлэх, хадгалж авч үлдэх боломжийг хязгаарлаж байна.

Багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагад дурдсанаар, төслийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж буй сургуулиудын хувьд сургуулийн удирдлага болон эцэг эхчүүдийн оролцоо, дэмжлэг ихээхэн дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, эцэг эхчүүдийн зөвлөл нь идэвхтэй ажиллаж буй сургуулиудын хувьд хичээлээс гадуурх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, ангийн булан болон самбаруудыг бэлтгэх зэргээр дэмжлэг үзүүлж байна. Мөн идэвх, санаачилгатай эцэг эхчүүд багшийн сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хөгжүүлэх болон хичээл заах үед туслах зэргээр багшийн сургалтын үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Энэ нь багш нарын хүүхэд болгонтэй ажиллах ачааллыг бууруулж, багш нарыг сургалтын агуулгад анхаарал хандуулах, эцэг эхийн тусламжтайгаар хүүхдийн суралцах чадварыг гэрт болон сургуулийн орчинд хөгжүүлэх боломжийг бүрдүүлдэг ажээ.

Үр дүнгийн үзүүлэлт 1.2

Үр дүнгийн үзүүлэлт 1.2:

Төсөлд хамрагдах сургуулийн анги даасан багш нарын 80% нь хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хянах, ашиглах арга зүй эзэмшсэн байна.

Эцсийн үнэлгээний үзүүлэлт: 89.8 %

Мэдээллийн эх сурвалж: Багш нарын асуумж, багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлага

Гол үр дүн

Хүүхдийн хувийн мэдээллүүдийг илрүүлж, хүүхдийн хөгжлийн чадварыг бодитойгоор үнэлж дүгнэн эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн ажилтнуудтай хамтран сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах нь сургуульд дасан зохицох чадварыг дэмжих суурь юм. Төслийн зорилтын хүрээнд “Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах арга зүй” модулийн үндсэн сургалтаар зорилтот сургуулиудын 39 сургагч багш бэлтгэгдсэн ба 385 багш хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, мэдээллийг боловсруулах дотоод сургалтад хамрагдсан байна.

Судалгаанд оролцогч зорилтот сургуулийн багш нарын 99.7 хувь буюу 371 нь хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж байгаа бол зорилтот бус сургуулиудын багш нарын 97.7 хувь буюу 129 нь ажилдаа ашиглаж байна гэж хариулсан байна.

Дүрс 5. Сурагчийн хувийн мэдээллийг цуглуулах байдал (%)




Төслийн хүрээнд багш нарын хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хянах, ашиглах арга зүйг “Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах” модулиар дамжуулан олгосон. Тиймээс багш нарын уг арга зүйг эзэмшсэн байдлыг уг модулийн мэдлэг ойлголтыг хэрэглэж буй байдал, арга аргачлалыг ашиглаж буй байдал болон үнэлгээний аргачлалыг ашиглаж буй байдалдаа эерэг үнэлгээ (маш сайн ба сайн) өгсөн багш нарын хувиар тооцсон. Зорилтот сургуулийн багш нарын асуумжийн үр дүнгээс харахад, багш нарын **89.8 хувь** нь хүүхдийн мэдээллийг цуглуулах, хянах, ашиглах арга зүйг маш сайн, сайн эзэмшсэн байна. Энэ үндэслэлээр “Төсөлд хамрагдах сургуулийн анги даасан багш нарын 80% нь хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хянах, ашиглах арга зүй эзэмшсэн байна” зорилт хангагдсан гэж үзэж байна.

Бусад үр дүн.

Судалгаанд оролцсон багш нар “Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах арга зүй” модуль сургалтад бараг бүрэн хамрагдсан ба сургалтын үр дүнг 33.9 хувь нь маш сайн, 54.3 хувь нь сайн, 10.5 хувь нь дунд зэрэг гэж үнэлж байна. Эндээс үзвэл багш нар хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах мэдлэг, ойлголт бий болсон байна. Харин зорилтот бус

сургуулиудын багш нарын 15.2 хувь нь маш сайн, 45.5 хувь нь сайн 31.0 хувь нь дунд, 3.8 хувь нь үр дүн муутай байсан хэмээн үнэлсэн байна.

Дүрс 6. Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах арга зүй модуль сургалтын үр дүн (%)



Анги удирдсан багш дунджаар 37 сурагчтай ажиллаж байгаа ба 1 сурагчийг 15 чадвар, үзүүлэлтээр үнэлж байна. Нэг хичээлийн жилд анги удирдсан багш 1-3 удаа⁴ мэдээлэл цуглуулж байна. Энэ модулийн хүрээнд багш нарт өгсөн гол арга зүй нь хүүхдийн мэдээллийг цуглуулах, MS Excel программ ашиглан судалгааны file үүсгэх, мэдээллийг оруулах, сурагч тус бүрийн дундаж оноог бодох, ангийн дундаж оноог бодох, улирлын үр дүнг харьцуулах, хичээлийн жилийн эхний үр дүнг эцсийн үр дүнтэй харьцуулах, эцэг эх асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх аргачлалууд юм.

Эдгээр арга зүй, аргачлалыг багш нар ажилдаа хэрхэн ашиглаж байгааг авч үзвэл хүүхдийн хувийн мэдээллийг үнэлэх үнэлгээний аргачлалыг ашиглах байдлыг 32.5 хувь нь маш сайн, 57.0 хувь нь сайн гэж дүгнэж байна. Арга зүй, аргачлалыг 33.3 хувь нь маш сайн, 56.7 хувь нь сайн ашигладаг гэж өөрийгөө үнэлсэн бол энэ чиглэлийн мэдлэг ойлголтыг 32.3 хувь нь маш сайн, 57.8 хувь нь сайн ашигладаг гэж үнэлжээ.

Багш нарын хувьд үр дүнтэй ашиглаж байгаа хүүхдийн мэдээлэл нь эрүүл мэндийн мэдээлэл (58.8%), сэтгэн бодох чадвар (55.0%), бусадтай харилцах чадвар (51.2%), бие даан суралцах чадвар (48.5%), болон зан төлөвийн мэдээлэл (47.7%) байна. Харин багш нарын хувьд бүрэн ашиглаж чадахгүй байна гэж үзсэн мэдээллүүд нь хүүхдийн өөрийгөө удирдах чадвар (14%), жижиг бүлчингийн хөгжлийн талаархи мэдээлэл (14.0%) мэдээлэл технологитой харилцах чадварын мэдээлэл (16.7%), СӨБ-д хамрагдаагүй хүүхдийн эцэг эхийн мэдээлэл (29.4%) байна.

Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах аргачлалуудыг ашиглахад анги удирдсан багшийн зүгээс дэс дараатай гүйцэтгэл, цаг хугацаа, мэдээлэл боловсруулах чадвар, хамтын ажиллагаа ихээхэн шаарддаг тул багш бүр ажилдаа чадварлаг ашиглах байдал харилцан адилгүй байна.

Хүснэгт 3. Зорилтот сургуулиудад хүүхдийн мэдээллийг ашиглах байдал (%)

Мэдээллийн эх сурвалж	Хүүхдийн мэдээлэл	Бүрэн ашиглаж чадахгүй байна	Зарим үед л ашиглаж байна	Бүрэн ашиглаж байна
Нийгмийн	Хүүхдийн хувийн мэдээлэл	7.8	52.0	40.2

⁴ Хичээлийн жилд эрүүл мэндийн мэдээлэл нэг удаа авдаг бол танин мэдэхүйн чадвар, хэл нийгмийн чадвар, амьдрах ухааны чадварын мэдээллийг хавар, намар 2 удаа авдаг.

ажилтан, багш	Хүүхдийн эцэг эх, гэр бүлийн талаарх мэдээлэл	7.8	45.3	46.9
	СӨБ хамрагдаагүй хүүхдийн эцэг эхээс авах асуулга	29.4	51.5	19.1
СӨБ-д хамрагдаагүй хүүхдийн эцэг эх	Жижиг булчингийн хөгжлийн талаарх мэдээлэл	17.8	42.6	39.6
	Танин мэдэхүйн хөгжлийн талаарх мэдээлэл	9.2	49.1	41.8
	Зан төлөв, өөрийгөө илэрхийлэх чадварын мэдээлэл	7.0	45.8	47.2
	Давуу тал ба дадал хэвшлийн талаарх мэдээлэл	8.4	51.5	40.2
Цэцэрлэгийн багш	Танин мэдэхүйн хөгжлийн мэдээлэл	7.0	54.4	38.5
	Өөрийгөө илэрхийлэх чадварын мэдээлэл	9.2	47.4	43.4
	Өөрийгөө удирдах чадварын мэдээлэл	14.0	55.8	30.2
Багш	Жижиг булчингийн хөгжлийн мэдээлэл	14.0	47.4	38.5
	Хамтран суралцах чадвар	7.5	44.7	47.7
	Хүүхдийн бусадтай харилцах чадвар	6.2	42.6	51.2
Багш, эцэг эх	Бие даан суралцах чадвар	7.3	44.2	48.5
	Эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох	4.3	36.9	58.8
	Байгаль орчинтой зөв харилцах чадвар	7.3	49.1	43.7
	Мэдээлэл, технологитой ажиллах чадвар	16.7	53.9	29.4
Багш	Сэтгэн бодох чадвар	4.9	40.2	55.0
	Асуудал шийдвэрлэх чадвар	7.0	52.3	40.7

Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах үйл ажиллагаанд тулгарч байгаа бэрхшээлүүдийг багш, менежерүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс тодруулан авч үзвэл:

- *Багш нарт:* Ажлын ачаалал их, анги дүүргэлт их, нэмэлтээр хийхэд хүндрэлтэй, зарим сургууль интернетэд холбогдоогүй, хугацаа давчуу байдаг
- *Эцэг эхийн зүгээс:* Зарим эцэг эхчүүд идэвхгүй, үнэлгээний мэдээллийн ач холбогдлыг ойлгодоггүй, хүүхдийнхээ хөгжил чадварыг хэтрүүлэх үнэлэх хандлагатай, боловсролын түвшин доогуур байдал
- *Орон нутгийн байгууллагуудын зүгээс:* Зарим хороо, өрхийн эмнэлэг, цэцэрлэг зэрэг төрийн байгууллагын албан хаагчдын ажлын байрны тогтворгүй байдал, удирдлагын идэвхгүй оролцоо зарим сургуулиудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна.

Зорилтот сургуулиудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах чиглэлээр дараах үйл ажиллагаануудыг тусган хэрэгжүүлж байна.


Хүснэгт 4. Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах чиглэлээр хийгдсэн үйл ажиллагаанууд

№	Үйл ажиллагаа
1	“Хувийн хавтас” хүлээлцэх үйл ажиллагаа /09.01/ хийгдэж байна
2	Сурагчийн хөгжлийн хавтас нээсэн.
3	БСШУСЯ-ны “Боловсролын Удирдлага Мэдээллийн Систем”-д “Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах арга зүй” (төслийн модуль 1.2) модулийн 1, 2-р бүлгийн хүүхдийн талаар мэдээлэл цуглуулах асуулгуудыг нэгтгэж оруулсан. Мөн уг системийн судалгааны модулийн хэсэгт 4-р бүлгийн “хүүхдийн хөгжил чадварын ахиц”-ын мэдээлэл цуглуулах асуулгуудыг оруулсан.
4	Цуглуулсан мэдээллийг Боловсролын Удирдлага Мэдээллийн Системд хэрхэн оруулах сургалтыг БСШУСЯ-тай хамтран зорилтот сургуулийн менежер, секцийн ахлагч, багш нарт зориулан 2 удаа

	зохион байгуулсан. Сургалтын үр дүнд мэдээллийн системд сургуулийн түвшинд цуглуулсан мэдээллээ оруулах, мэдээлэл татаж авах, дүн шинжилгээ хийх талаар зохих чадвар, туршлага хуримтлуулж байна.
5	СӨБ-д хамрагдаагүй хүүхдийн эцэг эхээс хүүхдийн хөгжлийн мэдээллийг 4 чиглэлээр авч байна.
6	Цэцэрлэгийн багшаас 4 чиглэлээр хүүхдийн хөгжлийн мэдээлэл авч байна.
7	Багш хүүхдийн ерөнхий мэдээлэл болон танин мэдэхүйн чадвар, хэл нийгмийн чадвар, амьдрах ухааны чадвар, эрүүл мэндийн мэдээллийг авч байна
8	Багшийн ажлын төлөвлөгөөнд хүүхдийн хувийн мэдээллийг авах, нэгтгэн дүгнэх ажил тусч, гүйцэтгэж байна.
9	Мэдээллийг MS Excel програм дээр боловсруулах арга зүйн чадвар сайжирсан.
10	Сурагчдын хувийн мэдээллийн бааз 2015, 2016 /CD/ үүссэн.
11	Сар бүр хүүхдийн чадварын үнэлгээг хийдэг болсон.

Зорилтот сургуулийн багш нарын ажлын төлөвлөгөөнд хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах ажил тусгагдан хичээлийн жилийн явцад үе шаттайгаар хэрэгжиж байна.

Дүрс 7. Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах аргачлалын цикл



Багш нарын хүүхдийн мэдээллийг баримтжуулж буй байдлыг авч үзвэл сурагчдын бүтээл, эцэг эхтэй харилцах дэвтэр⁵, гэрэл зураг, ажиглалтын тэмдэглэлийг түлхүү ашиглаж байна.

Хүснэгт 5. Хүүхдийн хувийн мэдээллийг баримтжуулалт (%)

Төрлүүд	Зорилтот сургууль		Зорилтот бус сургууль	
	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Гэрэл зураг	71.2↑	28.8	76.0↑	24.0
Ажиглалтын тэмдэглэл	61.2	38.8	61.2	38.8
Ярилцлагын тэмдэглэл	36.4	63.6↓	32.6	67.4↓
Хяналтын хуудас	54.4	45.6	55.0	45.0
Зураг, наамал, баримал зэрэг бүтээл	88.9↑	11.1	92.2↑	7.8
Эцэг эхтэй харилцах дэвтэр	76.5↑	23.5	55.0	45.0

Хүүхдийн хувийн мэдээлэл цуглуулахад таамаглалаар гаргах тохиолдол гардаг. Жишээ нь залуу багш нарын хувьд хүүхдийн зарим нэг чадварыг үнэлэхдээ ямар байвал сайн, дунд, муу гэж үнэлэх талаар ойлголт сул байдаг. Туршлагатай багш нар өөрсдийн ажиглалт, туршлагаар үнэлдэг. Эцэг, эхчүүд хүүхдээ хэзээ ч оношилж үзээгүй, дандаа худал оношилдог, хүүхэддээ үнэнийг хэлдэггүй, хүүхдээ үнэлж мэддэггүй, энэ байдлаас болж багш хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах тал дээр зөрүү алдаа гардаг.

УБ. Баянзүрх дүүрэг. Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас

Сургуулиудад хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулахдаа цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн хөгжил чадварын ерөнхий мэдээллийг цэцэрлэгийн багшаас дөрвөн чиглэлээр цуглуулж, цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийн эцэг эхээс асуулгын аргаар мэдээлэл цуглуулж, боловсруулж сургуульд бэлэн байдлыг үнэлж байна.

Хүснэгт 6. “Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах арга зүй” модулийн хэрэгжилтийн өмнө болон дараах байдал

Төслийн ӨМНӨ	Төслийн ДАРАА
Багш нарт хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах ойлголт, арга зүйн чадвар дутмаг байсан	Багш нар хүүхдийн хувийн мэдээллийн ач холбогдлыг ойлгох болж арга зүйн мэдлэг, аргачлал сайжирсан
Багш, эцэг эх зэрэг тогтсон эх сурвалжаас мэдээлэл авдаг	Олон эх сурвалжаас мэдээлэл цуглуулж байна. /эцэг, эх асран хамгаалагч, багш, сургуулийн эмч, цэцэрлэгийн багш, нийгмийн ажилтан/
Уламжлалт аргачлалаар мэдээлэл цуглуулдаг	Excel мэдээллийг оруулах, боловсруулах, мэдээллийн сан бий болсон
Жилд нэг удаа /намар/бүртгэл судалгаа авдаг	Сургалтын хугацаанд давтамжтай мэдээлэл авдаг болсон
Цаасан мэдээлэл	Цахим мэдээлэл, харилцах дэвтэр, бүтээл
Цөөн асуултаар 1 төрлийн мэдээлэл авдаг	Цогц асуултаар төрөлжсөн мэдээлэл цуглуулдаг
Бүртгэл судалгаа-мэдээлэл	Хүүхдийг олон талаас нь судлах болсон.
Мэдээллийн ашиглалт бага	Мэдээлэл ашиглалт сайжирсан
Багшийн ажил үүрэгт мэдээлэл цуглуулах ажил тусгагдаагүй байсан.	Багш нарын энэ үйл ажиллагааг сургуулийн дотоод дүрэм журамд тусган ажлын үнэлгээ, урамшууллын тогтолцоонд оруулж өгсөн байна
Багш сурагчийн харилцаа албан хэлбэрээр байсан.	Багш сурагчийн харилцаа сайжирсан
Сурагчдын хувийн онцлогтой холбон сургалтыг зохион байгуулах уламжлалт арга зүйтэй байсан	Судалгааны мэдээлэлд тулгуурлаж хүүхэд нэг бүртэй ажиллах төлөвлөгөө гаргадаг
Үнэлгээний аргачлал байгаагүй	Үнэлгээний хуудас ашиглах болсон

Энэ модулийн дагуу багш нарын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь Монголын боловсролын тогтолцоонд анх удаа сурагчдын хувийн мэдээллийг цогц байдлаар цуглуулж, 1-р ангийн сурагчдын сургалтын үйл ажиллагаанд ашиглах эхлэл болсон байна.

Өмнө нь хавар 1-р ангид хүүхэд бүртгэхэд хүүхдийн төрсний гэрчилгээ, эцэг эхийн бичиг баримтаа авч ирээрэй л гэдэг байсан бол **одоо** СӨБ-н багш нартай хамтраад ажиллаж сурлаа. СӨБ төгссөн хүүхдүүдийн хувийн мэдээллийг хүлээлгэж өгдөг болсон.

Өмнө нь нэг мэдээлэл авчихаад түүнийгээ ашиглахдаа муу байсан бол ... **одоо** энэ мэдээллийг ашиглаад хүүхдийн суралцах чадварт ямар ахиц гарсан бэ гэдгийг буцаад ээж аавд нь танилцуулдаг болсон нь их үр дүнтэй.

Одоо сургуулийн ажлын төлөвлөгөөнд хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах ажил тусгагдсан.

УБ. Чингэлтэй дүүрэг. Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас

Цаашид хүүхдийн мэдээллийг цуглуулж байгаа ч мэдээллийн санг бүрэн ашиглах, үнэлгээний асуултуудыг сайжруулах, мэдээллийн нэгдсэн системд оруулах, мэдээлэл боловсруулах үр чадвараа дээшлүүлэх, багш нарыг давтан сургалтад хамруулах замаар улам боловсронгуй болгох шаардлагатай гэж багш нар үзэж байна.

4.2. Сургуулийн дэмжих бүтэц, тогтолцоо

Энэхүү дэд бүлэгт төслийн Зорилт 2 буюу “Зорилтот сургуулиудад нэгдүгээр ангийн хүүхдийн суралцах чадварыг дэмжих ялангуяа сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдэд сургуульд дасан зохицох, суралцах чадвар эзэмшихэд туслах бүтэц, тогтолцоо бүрдүүлэх” ажлын үнэлгээний үр дүнг танилцуулна.

Уг зорилгын үр дүнг төслийн баримт бичигт дурдсан дараах хоёр үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлжээ.

Үр дүнгийн үзүүлэлт 2.1:

Бүх зорилтот сургуулиудад “Бэлтгэл хөтөлбөр”-ийг хөгжүүлж, өөрийн үнэлгээний тогтолцоог бий болох, үр дүн туршлагаа зорилтот бус сургуулиудад түгээх чадвартай байх

Эцсийн үнэлгээний үзүүлэлт: Бүх (24)

Мэдээллийн эх сурвалж: Багш нарын асуумж, сургуулийн сургалтын менежерүүд, захиралуудтай хийсэн ярилцлага

Үр дүнгийн үзүүлэлт 2.2:

Бүх зорилтот сургуулиудад “Сургуулийн бэлтгэл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутгийн төрийн байгууллагуудтай тогтвортой хамтын ажиллагааны механизм бүрдүүлсэн байна.

Эцсийн үнэлгээний үзүүлэлт: Бүх (24)

Мэдээллийн эх сурвалж: Багш нарын асуумж, сургуулийн сургалтын менежерүүд, захиралуудтай хийсэн ярилцлага

“Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр”-т заасны дагуу сургуулийн бүтэц, тогтолцоо бүрдсэн эсэхийг дараах 6 дэд асуудлаар үнэлдэг. Үүний дагуу дэд асуудал тус бүрийг судалж, сургуулийн бүтэц тогтолцоо сайжирсан эсэхийг үнэллээ.

4.2.1. Сургуулийн бодлого

Зорилтот сургуулиудад нэгдүгээр ангийн хүүхдийг сургуульд дасан зохицох суралцах чадварыг дэмжих бодлогыг бий болгох чиглэлээр сургуулийн бодлого төлөвлөгөө, дотоод журамдаа өөрчлөлтүүдийг оруулсан. Бодлого эрх зүйн орчин бүрдсэн нь төслийн хүрээний аргачлал, арга зүйг сургуульдаа тогтвортой хэрэгжүүлэх боломжийг олгож байна.

Дүрс 8. Нэгдүгээр ангийн сурагчдыг дэмжих сургуулийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд

Хийгдсэн ажлууд

- Сургуулийн хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт орсон.
- Ажлын байрны тодорхойлолтыг шинэчилсэн.
- Сургуулийн дүрэм /багш, ажилтан, сурагч/-д өөрчлөлт орсон.
- Сургуулийн дэг /сургууль, анги, орчин/-д өөрчлөлт орсон.
- Сургуулийн ажилтнуудын оролцоонд үнэлгээ хийдэг болсон.
- Сургуулийн гадна дотно орчинд дүн шинжилгээ хийдэг болсон.
- Сургуулийн хичээлийн жилийн төлөвлөгөөнд дасан зохицох үйл явцыг дэмжих талаар тусгагдсан.
- Заах аргын нэгдлийн ажлын төлөвлөгөөнд дасан зохицох үйл явцыг дэмжих талаар тусгагдсан.
- Багшийн ажлын төлөвлөгөөнд дасан зохицох үйл явцыг дэмжих талаар тусгагдсан.
- Хамтран ажиллах байгууллагуудтай гэрээ хийж, ажлын төлөвлөгөө гаргасан.

Төслийн бүтэц, тогтолцоог сургуулийн үйл ажиллагаанд нийцүүлэхийн тулд эрх зүйн зохицуулалт хийн шинэчлэх, боловсронгуй болгох ажлууд зорилтот сургуулиудад хэрэгжсэн байна.

Хүснэгт 7. БЗД-ийн 79-р сургуулийн дотоод дүрэм, журмын өөрчлөлт

№	Бодлого, эрх зүйн зохицуулалт	Өөрчлөлт
1.	Хөдөлмөрийн гэрээ	Нэмэлт өөрчлөлт
2.	Ажлын байрны тодорхойлолт	8 ажлын байрны тодорхойлолт шинэчилсэн
3.	Сургуулийн дотоод журам	10 заалт
4.	Сургуулийн дүрэм	2 заалт

Мөн төслийн сургуулиудад нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих үйл ажиллагааг сургуулийн удирдлагаас бодлогоор дэмжин нэгдүгээр анги даан ажиллаж байгаа багшид үр чадварын урамшуулал (цалингийн 20 хувь)-ыг улирал тутам олгох тодорхой заалтыг оруулсан нь багш нарын үр чадвар ахихад эерэгээр нөлөөлж байна.

2016-2017 оны хичээлийн жилд нэгдүгээр ангийн сурагчдын бэлтгэл хөтөлбөр 80 цагаар хичээллэж байсныг төслийн хамтын ажиллагааны үр дүнд сайжруулан 60 цагийн “Бэлтгэл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна.

Зорилтот сургуулиуд бэлтгэл хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэж байна.

Дүрс 9. Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд

Хийгдсэн ажлууд

- "Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" сургалтыг зохион байгуулсан
- Сургуулийн бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна
- Бэлтгэл хөтөлбөрийн тайланг хэлэлцэж байна
- Нэгдүгээр ангийн сурагчдыг бүртгэх, элсүүлэх журмыг шинэчилсэн
- Зуны сургалт зохион байгуулж байна
- Дасгал ажлын дэвтрийг бэлтгэл хөтөлбөрт үр дүнтэй ашиглаж байна
- Сургуулийн элсэлтийн бүртгэлийг зохион байгуулж байна
- Сургуулийн өөрийн үнэлгээг хийдэг болсон байна
- “Эцэг эхчүүдэд зориулсан сургуулийн танилцуулга”, “Эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага”-ыг зохион хэвлэн гаргаж 2016, 2017 оны сургуульд элсэгчдийн эцэг, эхчүүдэд өгсөн байна
- Ангид мөрдөх дэг, хичээлийн хуваарийг хэвшүүлэн ажиллаж байна
- Бэлтгэл хөтөлбөрийн сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэн ашиглаж байна
- БСШУСЯ-ны сурах бичгийн нэгдсэн жагсаалтад орсон "Бэлтгэл I - (Дасгал ажлын дэвтэр)" орсон
- Багшийн үнэлгээний хуудас ашиглаж байна
- “Сургуулийн ертөнцөөр”, “Тоглоомын ертөнцөөр”, “Үлгэрийн ертөнцөөр” сэдвүүдийг заасан

1-р ангид элсэж буй хүүхдийг сургуульд хүлээн авах үйл ажиллагаанд сургуулийн зүгээс хэрхэн дэмжлэг үзүүлж байгааг 2015 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулан авч үзье.

Хүснэгт 8. Нэгдүгээр ангид элсэж буй сурагчдыг хүлээн авах бэлтгэл ажил дах сургуулийн дэмжлэг (%)

Сургуулийн дэмжлэг	Сургалтын менежер			ЗАН, 1-р ангийн багш нарын секц		
	2015	2018	Зөрүү ⁶	2015	2018	Зөрүү
Багш нарт зориулан 1-р ангийн бэлтгэл хөтөлбөрийн, хүүхдийг дасах, хүлээж авах тухай чиглэлээр сургалт зохион байгуулах	73	93	20	64	91	27
1-р анги даасан багш нартай шинээр сургуульд ирж байгаа хүүхэдтэй ажиллахад гарч буй хүндрэлийн талаар ярилцаж зөвлөх	56	91	35	69	90	21
1-р ангийн хөтөлбөр (бэлтгэл хөтөлбөр, хичээлүүдийн хөтөлбөр), сурах бичгээр хангах, ангийн орчинг тохижуулах	83	89	6	64	90	26
Сургуульд элсэгч хүүхэд, эцэг эхчүүдийг багшийн зүгээс сургуулийн үйл ажиллагаатай танилцуулах үйл ажиллагаа зохион байгуулах	73	94	21	56	89	33
1-р ангийн хүүхдийн гэр бүлд нь зочилж үүлэх ажлыг зохион байгуулах	30	48	18	28	54	26
Цэцэрлэгийн багш, сургуулийн 1-р анги даах багш нарын туршлага, мэдээлэл солилцох үйл ажиллагаа	26	83	57	26	80	54
Сургуулийн 1-р анги даасан болон нэгдүгээр анги шинээр даах багш нарын хооронд туршлага, мэдээлэл солилцох үйл ажиллагаа	60	88	28	52	87	35
1-р ангийн шинэ сурагчдын мэдлэг чадварын түвшинг тогтоох судалгаа хийх	70	88	18	64	85	21
Багшийн ажлыг үнэлэхдээ шинэ ангитай ажиллаж байгаа онцлогийг тооцох	61	83	22	50	78	28
Судалгааны мэдээлэлд тулгуурлаж хүүхэд нэг бүртэй ажиллах төлөвлөгөө боловсруулах	50	76	26	59	81	22
Сургуулийн бусад ажилтнуудыг 1-р ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжих ажиллагаанд татан оруулах	56	84	28	63	81	18
	Өндөр өсөлттэй			Өндөр өсөлттэй		

Зорилтот сургуулийн багш нар өөрсдийн сургуулийн удирдлага, менежерийн зүгээс дараах асуудлуудад илүү анхаардаг болж, ахиц гарсан гэж үнэлжээ. Үүнд:

- Сургуулийн менежер, удирдлагын хувьд цэцэрлэгийн багш, сургуулийн 1-р анги даах багш нарын туршлага, мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулах - 308 багш (83%)
- 1-р анги даасан багш нартай шинээр сургуульд ирж байгаа хүүхэдтэй ажиллахад гарч буй хүндрэлийн талаар ярилцаж зөвлөх үйл ажиллагаа - 340 багш (91%)
- Сургуулийн 1-р анги даасан болон нэгдүгээр анги шинээр даах багш нарын хооронд туршлага, мэдээлэл солилцох үйл ажиллагаа - 329 багш (88%)
- Сургуулийн бусад ажилтнуудыг 1-р ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжих ажиллагаанд татан оролцуулах - 311 багш (84%)
- Судалгааны мэдээлэлд тулгуурлаж хүүхэд нэг бүртэй ажиллах төлөвлөгөө боловсруулах - 283 багш (84%)

⁶Хувиар

Заах аргын нэгдэл (ЗАН), нэгдүгээр ангийн багш нарын секцийн үйл ажиллагаанд ахиц гарсан чиглэлүүдийг авч үзвэл:

- Цэцэрлэгийн багш, сургуулийн нэгдүгээр анги даах багш нарын туршлага, мэдээлэл солилцох үйл ажиллагаа - 296 багш (80%)
- Сургуулийн 1-р анги даасан болон нэгдүгээр анги шинээр даах багш нарын хооронд туршлага, мэдээлэл солилцох үйл ажиллагаа - 323 багш (87%)
- Сургуульд элсэн орох хүүхэд, эцэг эхчүүдийг багшийн зүгээс сургуулийн үйл ажиллагаатай танилцуулах нээлттэй үйл ажиллагаа зохион байгуулах - 331 багш (89%)
- Багшийн ажлыг үнэлэхдээ шинэ ангитай ажиллаж байгаа онцлогийг тооцох - 290 багш (78%)
- Багш нарт зориулан 1-р ангийн бэлтгэл хөтөлбөрийн, хүүхдийг дасах, хүлээж авах тухай чиглэлээр сургалт зохион байгуулах - 338 багш (91%)

4.2.2. Сургуулийн орчин

Зорилтот сургуулиуд нэгдүгээр ангийн сурагчдын анги танхимийн эрүүл ахуй, ариун цэвэр, хүүхдийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангах чиглэлээр олон үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

Хүснэгт 9. Сургалтын орчны шинэчлэл

Хүүхдэд ээлтэй орчин	Үйл ажиллагаа
Анги танхим	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн анги, самбар, ширээ, сандлыг солих, номын булан, тоглоомын булан, хүүхэд хөгжлийн булан, хүлээлгийн өрөө байгуулах, хувцасны шүүгээ, өлгүүр, хаясан гээсэн зүйл хадгалах хэсэг, эцэг эхчүүдэд зориулсан мэдээллийн самбар зэрэгт журам гаргах, шинээр хийх, сайжруулах зэргээр орчны стандартад тавих шаардлагыг ханган ажилласан байна.⁷
Номын сан	<ul style="list-style-type: none"> • Сургууль бүрийн номын санд 1-р ангийн сурагчдад зориулсан ДЗСЧ-ыг дэмжсэн номын булантай болсон.⁸ • Зорилтот 24 сургуульд тус бүр 53 ширхэг үлгэрийн болон уран зохиолын ном хандивласан. • Сургуулиуд уг номнуудыг номын сан, “Хүүхэд хөгжлийн танхим”-даа байрлуулан сурагчдаар уншуулж байна. • Сургуулийн номын санчдыг сургалтад хамруулснаар нэгдүгээр ангийнханд чиглэсэн үйл ажиллагаанд илүү оролцож, Ном унших цаг”-ийн хуваарь гарган ном уншиж өгдөг болжээ. • Хүүхдийг уншиж сургах, номонд дуртай болгох аянг зохион байгуулж эцэг эхчүүдийг оролцуулан ажиллаж байна.

1-р ангийн хичээлийн хуваарьт зарим сургууль өөрчлөлт оруулж 1,2-р ээлжинд хичээллэдэг болсон байна. Төслийн зүгээс зорилтот сургуулиудад хүүхэд гэрийн даалгавраа хийх, хичээлээ давтах, тоглох боломжтой хүүхдэд ээлтэй орчинг бий болгох зорилгоор “Хүүхэд Хөгжлийн Танхим”-ыг байгуулахад материаллаг туслалцаа үзүүлсэн байна. Ийнхүү хүүхдүүд тав тухтай орчинд цагийг үр бүтээлтэй өнгөрөөж байгаа нь тэдний сургуульдаа илүү дасан зохицох, суралцах чадварыг сайжруулахад тус дөхөм болж байна. Сургуулийн орчинд үнэлгээ хийдэг

⁷БЗД-ийн 92-р сургууль. Эцэг эхчүүдэд зориулсан сургуулийн танилцуулга. УБ., 2017 он. Сургуулийн орчин. 19х.

⁸БЗД-ийн “Амгалан” цогцолбор сургууль. Эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага. УБ., 2016 он. Сургуулийн үйлчилгээ. 12х.

болж нэгдүгээр ангийн хүүхэд суралцахад шаардлагатай эрүүл, аюулгүй орчин бүхий ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, эмчийн өрөө, номын сан, цайны газар ажиллаж байна.⁹

Сургуулийн гадна орчны зураглалыг гарган хүүхдүүдэд танилцуулж тайлбарлан, сургуулийн анги танхимын тэмдэг, тэмдэглэгээг байрлуулан нүдлүүлэх ажил хэвшсэн байна.¹⁰ Тухайлбал: СХД-ийн 104-р сургуульд уурын зуух, далан, ажлын өрөө, эмчийн өрөө, номын сан, эмэгтэй ариун цэврийн өрөө, эрэгтэй ариун цэврийн өрөө, хөгжмийн өрөө, цахилгаан талбай, гал тогоо,

- *Төслөөс санаа аваад 1-р ангийн хүүхдүүд таних тэмдэгтэй байх хэрэгтэй юм байна гээд 1-р ангийнхан нил ягаан үсний лент зүүдэг, 2-р ангийнхан ногооныг, 3-р ангийнхан цэнхрийг, 4-р ангийнхан улаан лент, 5-р ангийнхан ягааныг зүүдэг болсон. Энэ хичээлийн жилээс улаан ленттэй ангийн хөвгүүд улаан зангиа, ногоон ленттэй охидуудын ангийн хөвгүүд ногоон зангиа зүүдэг болсон.*
- *1-р ангийнхан уншиж чадахгүй болохоор жижиг жижиг таних тэмдгүүдийг хийснээр хүмүүс өхөөрдөөд хүүхэдтэй харилцах эерэг харилцаа үүсч байгаа юм.*
- *Өмнө нь сургуулийн хаалгаар айгаад чичрээд л ордог байсан бол одоо бүх хүүхдэд таних тэмдэг хийж өгсөн учир хүн болгон нэрээр нь дуудаад л харьцахад илүү дотно мэдрэмж авч байгаа.*
УБ. Чингэлтэй дүүрэг. Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас

биеийн тамирын өрөө илэрхийлэх тэмдэглэгээг байрлуулан ашиглаж байна.

Тусгай дугаарууд (101, 102, 103 гэх мэт)-ыг мэдүүлэх, хэрхэн ашиглах талаар сургалт орж, гэрэлтүүлэг хийх, замын хөдөлгөөний тэмдгийг таниулах, цагдаагийн байгууллагын

Хүүхдүүдээр гэрээс сургууль руу ирэхэд хамгийн аюултай зам, газруудын нэрлүүлж, зургийг гаргаж авсан. Маш олон хүүхэд харанхуй гудамж, нохойноос айдаг гэж хэлж байсан. Үүнийг захиралд мэдэгдэж зэрлэг нохойг устгуулах хүсэлт хороонд тавья гэсэн санал гаргасан. Гэхдээ манай захирал ач холбогдол, өгөхгүй байгаа учраас, би өөрөө хорооны даргатай уулзъя гэж бодож байгаа.
УБ. Чингэлтэй дүүрэг. Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас

сургалтуудыг хийх зэргээр аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа хийгдэж байна.

Сургууль болон анги танхимд нэгдүгээр ангийн сурагчдад сэтгэл зүйн ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр хавар бүртгээд сургуулийн орчныг танилцуулах аяллыг зорилтот 24 сургуульд тогтмол зохион байгуулж байна. Энэ хамтын үйл ажиллагааны үр дүнд сургуулийн захирал, менежер, багш, ажилтнууд, эцэг эхчүүдийн харилцаа ойртон, харилцан ойлголцол эерэгээр өөрчлөгдсөн байна.

4.2.3. Хүний нөөцийн чадавх

Сургуулийн удирдлагуудын хувьд нэгдүгээр ангийн сурагчийг сургуульд дасан зохицуулах талаар ойлголт, мэдлэгтэй болж, багш нарын хандлага ихээр өөрчлөгдсөн. Сургалтын менежер, 1-р ангийн секцийн ахлагч нар дотоод сургалтуудыг голлон зохион байгуулж, удирдлага, зохион байгуулалтаар ханган, манлайлж оролцож байна. Багш нарын өөрсдийн идэвх чармайлт, аргачлалыг илүү сайжруулж хувиргах бүтээлч арга барил, ажлын туршлага зэрэг нь

⁹СХД-ийн 122-р сургууль. Эцэг эхчүүдэд зориулсан сургуулийн танилцуулга. УБ., 2017 он. Сургуулийн орчин. 17х.

¹⁰БЗД-ийн тэргүүний 87-р сургууль. Эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага. УБ., 2016 он. Сургуулийн орчин. 14, 17х.

төслийн хэрэгжилт, үр дүнд нөлөөлсөн суурь хүчин зүйл байсныг судалгаанд оролцсон сургалтын менежерүүд (24 судалгаанд оролцогч) онцлон дурдаж байсан юм.

Хүснэгт 10. Бага ангийн багшийн үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт

№	Анхаарсан чиглэл	Үйл ажиллагаа
1	Багшийн хөгжлийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> • Модуль сургалтуудад хамрагдсан. • Багш нар нэгдсэн төлөвлөлт хамтарч хийж ажилладаг болсон ба ЗАН, 1-р ангийн багш нарын секцүүдийн үйл ажиллагааны төлөвлөлт, хамтын ажиллагаа сайжирсан. • Багшийн заах арга зүй сайжирсан. • Багшийн үнэлгээ хийгдэж байна. • Туршлага солилцох уулзалтуудад зөвлөгөө өгч туршлагаа танилцуулсан. • Модуль сургалтуудын арга, аргачлалуудыг эзэмшиж чадавхижсан. • Эцэг эхтэй харилцах арга зүй сайжирсан.
2	Ажлын орчин, нийгмийн асуудлаар	<ul style="list-style-type: none"> • 1-р ангийн багш нарт үр дүнгийн урамшуулал олгодог болсон. • Сургуулийн дотоод журамд 1-р ангийн багш нарыг жижүүр багшийн үүргээс чөлөөлсөн өөрчлөлт оруулсан.

Нэгдүгээр ангийн багш нарыг дэмжих, ажлын ачааллыг хөнгөвчлөх зорилгоор тодорхой ажлууд хийгдэж байна.

“1 сурагч-1 ажилтан” ажлаар сургуулийн ямар ч хамаагүй ажилтан 1-р ангийн бусдаасаа арай хоцрогдолтой хүүхдийг сонгон авч уншлага хийлгэдэг. Энэ ажлууд их сайн хэрэгжсэн. УБ. Чингэлтэй дүүрэг. Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас

Сургуулийн ажилтнууд болох номын санч, эмч нар, үйлчлэгч нар өмнө нь өрөөндөө л өөрийн чиг үүргийн ажлаа хийдэг байсан бол одоо хүүхдийн хөгжил, төлөвшилд гар бие оролцон багш, менежер ачааллыг маш ихээр хөнгөлж, нэгдүгээр ангийн хүүхдүүдийг дэмжин ажиллаж байна.

Хүснэгт 11. Сургуулийн ажилтнуудын оролцооны жишээнээс

Ажилтнууд	Оролцоо
Захирал, сургалтын менежер	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн дотоод журмуудад шинэчлэл хийсэн. • Сургалтын төлөвлөлтөд төслийн үйл ажиллагааны чиглэлүүдийг тусгасан. • Хэрэгжилт, тайлан, үнэлгээг удирдсан ажилласан. • Үндсэн сургалтад оролцсон. • Дотоод сургалтуудыг багш нарт удирдан явуулсан. • Эцэг эхчүүдэд зориулсан дотоод сургалт зохион байгуулж байна. • Төслийн сайн туршлагуудыг сурталчилж, түгээн дэлгэрүүлэх ажилд оролцсон.
Номын санч	<ul style="list-style-type: none"> • Сард нэг удаа бага ангийн сурагчдад ном уншиж өгдөг болсон. • Хуваарь гарган үлгэрийн ном уншиж өгдөг болсон. • Ангиудаар бяцхан номын сан аялуулдаг болсон. • Багш нар номын сантай хамтран жижиг, том ном зурган хэлбэрээр гаргасан.
Нийгмийн ажилтан	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн хөгжил чадварын мэдээллийг цуглуулах, нэгтгэн дүгнэх • Сургалт, уралдаан тэмцээн, эцэг эхийн үйл ажиллагаанд оролцох • Гэр бүлийн анхаарал дэмжлэг шаардлагатай хүүхдүүд, тэдний эцэг эхэд анхаарал хандуулан ажиллах
Сургуулийн эмч	<ul style="list-style-type: none"> • Хүүхдүүдийн өндөр жинг үзэж эцэг эхчүүдэд зөвлөгөө өгдөг • Гар угаах хэвшил • Шүд, амны хөндийн сургалт
Мэргэжлийн багш	<ul style="list-style-type: none"> • Уралдаан тэмцээн зохион байгуулдаг. • Дугуйлан, секц удирдан хичээллүүлдэг.

**Бусад ажилтнууд
/Үйлчлэгч,
жижүүр/**

- Өглөөний төрийн дуулал, бүжиг, гимнастик зэргийг одоо үйлчлэгч нар бие даан хариуцан хийлгэдэг болсон.
- 1-р ангийн хүүхдийг угтаж авахад өөрчлөлт орсон.
- Хүүхдүүдэд тусалж дэмждэг болсон.

Зорилтот сургуулиуд өөрсдийн туршлагаа бусад сургуулиудтай хуваалцсан нь төслийн үр нөлөөг өргөжүүлэх үр дүнтэй ажил болжээ. Нэгдүгээр анги даасан багш цэцэрлэгт хамрагдсан болон хамрагдаагүй хүүхдүүдийн хөгжлийн ялгааг харгалзан ажиллах мэдлэг, ойлголт, чадварыг модуль сургалтуудаар авсан ба хүүхэд болгонд хөгжил, чадварын график гарган цаашид хэрхэн хөгжүүлэх талаар эцэг эхчүүдтэй хамтран ажилласан байна. Бага ангийн багш нар сургуульд элсэгчдийн сургуульд бэлтгэгдсэн байдал, хувийн хөгжлийн онцлогийн талаар мэдээлэл цуглуулж ашиглах ойлголт, мэдлэг, туршлагатай болжээ.

4.2.4. Сургалтын үйл ажиллагаа

Зорилтот сургуулиудын 1-р ангийн ЗАН төлөвлөгөөндөө нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрийг зохион байгуулах, сургалтын дараагаар тайлан гаргаж үр дүнг хэлэлцэх ажил тусгаж үр дүнтэй хэрэгжүүлж байна.

- 1-р ангийн хүүхдүүдийн гарааны үнэлгээг тогтоон, судалгаа гарган цаашид хэрхэн хөгжүүлэх тал дээр ажиллах боломжтой болсон.
- Багш нарын идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд сургалтын материаллаг орчин бүрдсэн.¹¹ Анги бүр сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтыг цахимжуулж, сургалтдаа ашигладаг. Хичээлийн агуулгатай нийцсэн үзүүлэн, самбаруудыг хүүхдийн харааны түвшинд байрлуулсан.¹²
- Сургууль болон анги танхимд нэгдүгээр ангийн сурагчдыг хөгжүүлэх, сэтгэл зүйн ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр ажлуудыг соёл хүмүүжлийн ажлын төлөвлөгөөнд тусган багш, ажилтнууд, эцэг эхийн зөвлөл, хамтрагч байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулж хэвшсэн байна. Тухайлбал:
 - Зуны сургалт, бэлтгэл хөтөлбөр
 - “Миний сургууль” аялал, “Намрын аялал”
 - 6 настныг хүлээж авах нээлтийн үйл ажиллагаа, “Хувийн хавтас” хүлээлцэх үйл ажиллагаа
 - “Эцэг эхийн сургалт”, “Эцэг эхийн нэг өдөр”, “Аав, ээж, би”, “Ээжүүдийн өдөр”, “Аавуудын өдөр”, “Эцэг эхтэй харилцах дэвтэр”-ийн үнэлгээ
 - “Алтан намар” спорт наадам, “Урлагийн наадам”, “Сүлд модны наадам”, “Эрдмийн баяр”
 - “Тайлант уншлага”, “Ном унших сарын аян”, “Ном эмчлэх аян”
 - Төрөлжсөн дугуйлан
 - Эмч, цагдаа, нийгмийн ажилтнуудын мэргэжлийн сургалтууд зэрэг ажлуудыг жил бүр тогтмол зохион байгуулж байна.

Өмнө нь намар маш олон бүлэгт эцэг эх нь хүүхдээ дагуулаад гараас нь тас хөтлөөстэй явдаг байсан бол одоо хүүхэд сургуульдаа орохгүй гэж уйлах, гарч гүйх асуудал арай цэгцэрсэн. Мөн өмнө нь 1-р ангийн эцэг эхчүүдийг сургууль руу оруулахгүй гээд бөөн юм болдог байсан. Одоо 1-р ангийн хүүхдийг сургуульд дасан зохицох ёстой юм байна гэдгийг ойлгоод бүх ажилтан дэмжээд эцэг эх нь хөтлөөд анги уруу нь оруулдаг болсон.

УБ. Баянзүрх дүүрэг. Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас

14х.

¹²ЧД-ийн 61-р сургууль. Эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага. УБ., 2016 он. Бүлэг 4. Сургуулийн орчин. 15 х.

“1-р ангийн сурагч элсүүлэх, бүртгэх, хүлээн авах журам”, сургуульд баримтлах дэг, хувцасны өлгүүрт баримтлах дэг, завсарлагааны дэг, үдийн цайны дэг¹³, ангийн дүрэм зэрэг дүрэм журмуудад 1-р ангийн сурагчдын онцлогийг тусгасан байна.

4.2.5. Эцэг эхийн оролцоо

Төслийн үйл ажиллагааны үр дүнд сургууль, анги, бүлгийн эцэг эхийн зөвлөл шинэ бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй, шинэлэг аргачлалаар ажиллаж байна. Сургуулиудын төлөвлөгөөнд эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлүүд, бага ангийн эцэг эхийн зөвлөл байгуулах, эцэг эхтэй харилцах дэвтрийг хэрэгжүүлэх ажлууд тусгагдсан байна. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд эцэг эхчүүдийн оролцоо сайжирч, нэгдүгээр ангийн хүүхдийн дасан зохицох, суралцах чадварын тухай ойлголт, мэдлэг нэмэгдсэн байна. Энэ бүхэн нь бага ангийн багшийн ажлыг хөнгөвчлөх, хамтын ажиллагааг нэмэгдүүлж, сургууль, багшид хандах хандлагыг өөрчилж байна.

Дүрс 10. Эцэг эхтэй харилцаж буй арга хэрэгслүүд



Эцэг эхтэй харилцах дэвтрийн үйл ажиллагааг үнэлэх ажил анги удирдсан багш нарын ажлын төлөвлөгөөнд орсон туршлагүүд бий болжээ. Тухайлбал: СХД-ийн 122-р сургуулийн 1-р ангийн заах аргын нэгдлийн ажлын төлөвлөгөөнд сар бүрийн 4-р долоо хоногийн баасан гаригт¹⁴ багш үнэлэхээр тусгагдсан байна. Эцэг эх туслах багшаар ажиллах, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, уралдаан тэмцээн зохиох, сургуулийн орчинг сайжруулах, ажил мэргэжлийн туслалцаа үзүүлэх зэргээр ангийн багшийн ажилд туслан сургалтын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж байна.

4.2.6. Сургууль, орон нутгийн байгууллагын хамтын ажиллагаа

2015 он төслийн суурь суурь судалгааны үр дүнд “Сургууль болон бусад оролцогч талуудын хамтын ажиллагаа дутмаг байна” гэж дүгнэсэн бол 2018 оны судалгаагаар зорилтот

Төслийг хэрэгжихийн өмнө нь 1-р ангийн хүүхдийг бүртгээд, хуваарилалт хийгээд явдаг байсан бол одоо цэцэрлэгүүдтэй хамтарч ажиллаад, эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулж, цэцэрлэгийн хүүхдүүдийг сургуулийн орчинтой танилцах аялал хийлгэдэг болсон. Ингэснээр 1-р ангийн хүүхэд 9 сард орж ирэхдээ орчноо мэддэг, дасан зохицоход амар байдаг гэж ойлгож байгаа.

Гадаад түншлэлүүдийн хувьд сэтгэл хангалуун байгаа. Оны сүүлд хамгийн сайн түншлэгч гэсэн өргөмжлөл өгдөг. Энэ удаад 3-р хорооны өрхийн эмнэлэг шалгарсан. Мөн хүүхдийн төлөө хамгийн ойр дотно хамтарч ажилласан хүнээр хорооны засаг дарга шалгарсан.

УБ. Чингэлтэй дүүрэг. Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас

¹³СХД-ийн 61-р сургууль. Эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага. УБ., 2016 он. Сургуулийн бодлого дэг журам. 11х.

¹⁴СХД-ийн 122-р сургууль. Эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага. УБ., 2017 он. Бүлэг 1. Сургуулийн бодлого үйл ажиллагаа. 10х.

сургуулиудын хамтын ажиллагаа сайжирсан байна.

Суурь судалгааны үр дүнгээс харахад төсөл хэрэгжихээс өмнө сонгогдсон сургуулиудын орон нутгийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагаа нь төслийн зорилттой төдийлөн холбоотой биш, харилцан адилгүй байхаас гадна хамтын ажиллагааны зорилго, аргачлалын талаар мэдлэг огт байхгүй байсан. Нэгдүгээр ангийн сурагчдын гэр бүл, сургуулийн орчинд хамгийн ойрын анхан шатны төрийн байгууллагууд болох хороо, цэцэрлэг, өрхийн эмнэлэг хооронд мэдээлэл солилцох, хүүхдийг сургуульд бэлтгэхэд туслах үйл ажиллагааг хамтран төлөвлөж, хэрэгжүүлж болох хамтын ажиллагааны нөөц боломжийг төслийн хүрээнд илрүүлэн хамтын ажиллагааны эхлэлийг шинээр тавьсан байна. Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд бэлтгэгдсэн байдал, дасан зохицох чадварыг дэмжих чиглэлээр сургуулиас хамтран сургах тойргийн цэцэрлэг, хороо, өрхийн эмнэлэгтэй дараах байдлаар хамтран ажилласан байна.

Хүснэгт 12. Хамтрагч байгууллагуудын оролцоо

Хамтрагч	Үйл ажиллагаа
Хороо	<ul style="list-style-type: none"> 1-р ангид орох хүүхдүүдийн талаар мэдээлэл авах Эмзэг бүлгийн хүүхдүүдэд хорооны зүгээс хувцас өгөх гэх зэрэг ажлуудад хамруулах Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа хийх Орчны тохижилтыг шийдэх (гудамж талбайн гэрэлтүүлэг, зам гэх мэт) Үйл ажиллагаануудад өрөө, танхимыг нь ашиглах
Өрхийн эмнэлэг	<ul style="list-style-type: none"> Сурагч, эцэг эхчүүдэд эрүүл мэндийн сургалт явуулах Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах /шүд, гарын ариун цэвэр/, Вакцинд хамруулах
Цэцэрлэг	<ul style="list-style-type: none"> Цэцэрлэгтэй хамтран сургалт зохион байгуулах Хүүхдийн хөгжлийн судалгаа, мэдээлэл авах Танилцах аяллыг хамтран зохион байгуулах
Цагдаа	<ul style="list-style-type: none"> Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулах Сурагчдаас гарсан саналын дагуу орчны аюулгүй байдлыг хангах талаар зөвлөмж өгөх

Зорилтот сургуулиудад амжилттай хэрэгжсэн туршлагаадаас гадна сургамжтай, бэрхшээлтэй зүйлүүд тохиолдож байжээ. Сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн бүтэц тогтолцоог сайжруулахад тулгарч байсан бэрхшээл болон хүрсэн үр дүнг цаашид хадгалах талаар судалгаанд оролцогчид дараах саналуудыг гаргасан байна.

Хүснэгт 13. Төслийн хэрэгжилтийн үйл явцад судалгаанд оролцогчдын гаргасан санал

Сургуулийн бодлого	<ul style="list-style-type: none"> Анги дүүргэлт их байгаа Хичээлийг 2 ээлжинд оруулах Цалин, урамшууллын механизм хэрэгтэй байна Багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого хэрэгтэй байна
Хүний нөөц	<ul style="list-style-type: none"> 1-р ангийн багш нар маш их ачаалалтай ажилладаг Өмнө жил бэлтгэгдсэн 3 сургагч багш энэ жил бүгд солигдоод өөр тийш явсан Төсөл дуусаад сургалтуудаа үргэлжлүүлээд орёе гэхэд гарах зардал хязгаарлагдмал Сургуулийн удирдлагууд солигдохоор төслийг мэдэхгүй, санал зөрөлдөх асуудал тулгардаг Бусад багш нарын дэмжлэг сул, хандлага сөрөг байдаг
Эцэг эхийн оролцоо	<ul style="list-style-type: none"> Эцэг эхчүүдийн идэвх жигд нэмэгдэхгүй байна Боловсрол багатай эцэг эхийн идэвх оролцоо сул, харилцах дэвтэр бөглөхөд бэрхшээлтэй Эцэг эхчүүд хүүхдээ бодитоо үнэлдэггүй. Энэ үнэлгээ нь багшийн үнэлгээнээс зөрдөг Багшийн үнэлгээг хүлээн зөвшөөрдөггүй тиймээс хүүхдийн алдаа дутагдлыг засахад хэцүү

- Орон нутгийн байгууллагууд харилцан адилгүй идэвх оролцоотой байна
- Хамтран ажиллагч төрийн байгууллагын хүнд суртал, ажлын ачаалал их байх зэргээр төлөвлөсөн ажил хойшлогддог
- Хороо гэх мэт төрийн байгууллагын чиг үүрэгт 1-р ангийн хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх талаар тусгах хэрэгтэй
- Уулзалт хийсэн албан тушаалтантай санал бодлоо солилцоод тэр хүн нь удирдлага байгууллагадаа танилцуулах тал дээр ажил удааширдаг
- Хамтран ажиллаж байсан хүн нь солигдсон, мэдээлэл хүрээгүй гэх мэтээр ажил зогсдог

Төслийн бүхий л үйл ажиллагаа нь нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжих сургуулийн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн байна. Ялангуяа, сургалтын орчин, багш нарын чадавхи, эцэг эхчүүдийн хандлага оролцоо, сургуулийн ажилтнуудын хандлага, хамтрагч талуудын хамтын ажиллагааны суурь тавигдсанаар “Зорилтот сургуулиудад нэгдүгээр ангийн хүүхдийг сургуульд дэмжих бодлого бий болгох” төслийн дэд зорилт хангагдсан гэж үзэж байна.

Бүх зорилтот сургуулиудад төслийн үр дүнд нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх агуулга, арга зүйгээр хангагдсан байна гэж үзэж байна. Тухайлбал багш нарт 6 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал, сургуульд дасан зохицох чадварын тухай ойлголтыг эзэмшүүлэх, сургалтын арга зүйг сайжруулах (идэвхтэй сургалтын арга, оролцооны арга, тоглоомын арга ...) сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, СӨБ-д хамрагдаагүй хүүхдүүдийн сургуульд бэлтгэх арга зүйн ажлууд үр дүнтэй, институцилэгдсэн байгаа бөгөөд төсөл хэрэгжээгүй бусад сургуулиудад туршлагаа түгээх чадвартай байна гэж дүгнэж байна.

Бүх зорилтот сургуулиудад “Сургуулийн бэлтгэл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутгийн төрийн байгууллагуудтай тогтвортой хамтын ажиллагааны механизм бүрдүүлсэн байна гэсэн зорилт биелсэн байна. Зорилтот сургуулиуд хамран сургах тойргийн цэцэрлэг, хороо, өрхийн эмнэлэгтэй тогтвортой хамтран ажиллаж байна. Гэхдээ, зарим зорилтот сургуулиудын “Сургуулийн бэлтгэл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа нь эхлэлийн шатандаа байгаа, хөгжүүлэх, харилцан ойлголцох зэрэг тогтвортой механизм бүрдээгүй байгаа тохиолдлууд байна. Энэ нь төрийн байгууллагын албан хаагчдын хандлага, идэвх оролцоо, хамтын ажиллагааны туршлагаас хамаарч байна.

4.3. Эцэг эхчүүд

Энэхүү дэд бүлэгт төслийн Зорилт 3 буюу “Хүүхдийн суралцах чадварыг дэмжих талаар эцэг эх/асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлууд зохион байгуулах” зорилтын хүрээнд хийгдсэн ажлын үнэлгээний үр дүнг танилцуулна.

Төслийн дүнг үнэлэх зорилгоор Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн төслийн зорилтот болон зорилтот бус сургуулиудын 500 эцэг эхчүүдийг үнэлгээнд хамруулсан. Үнэлгээнд хамрагдсан эцэг эхчүүдийн олонхи нь бүрэн дүнд болон дээд боловсролтой байна. Мөн ажилгүй, төрийн байгууллага эсвэл хувийн компанид ажиллаж буй эцэг эхчүүд зонхилж байна. Мөн түүнчлэн бараг тал хувь нь хашаа байшинд, гурван өрх тутмын нэг нь гэрт амьдарч байна. Өрхийн орлогын хувьд олонх нь 300.000-аас 900.000 төгрөгийн орлоготой өрхүүд байна. Эдгээр үзүүлэлтүүд нь суурь судалгаанд оролцогч эцэг эхчүүдийн шинж байдалтай ойролцоо байна.

Төслийн эцэг эхчүүдэд үзүүлсэн үр нөлөөг төслийн баримт бичигт дурдсан хоёр үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлжээ.

Үр дүнгийн үзүүлэлт 3.1

Үр дүнгийн үзүүлэлт 1:

Зорилтот сургуулийн эцэг эхийн 80% нь олон хэлбэрээр багш нартай тогтмол харилцаж, зорилтот бус сургуулиудад туршлагаа түгээдэг байх

Эцсийн үзүүлэлт: 90.7%

Мэдээллийн эх сурвалж: Эцэг эхийн асуумж

Гол үр дүн

Энэхүү шалгуур үзүүлэлтийг ангийн хүрээнд зохион байгуулж эцэг эхийн сургалт, ганцаарчилсан зөвлөгөө, эцэг эхийн хурал гэх мэт эцэг эхтэй харилцах нийтлэг 8 төрлийн үйл ажиллагаанд оролцож буй эцэг эхчүүдийн хувиар тооцсон. Эцэг эхтэй харилцах дээрх олон төрлийн үйл ажиллагаанууд дахь 1-р ангийн эцэг эхийн оролцоог **90.7 хувьтай** байна.

Дүрс 11. Эцэг эхчүүдэд чиглэсэн үйл ажиллагаа, оролцооны хувь (%)



Дээрх дүрсээс харахад, зорилтот сургуулийн эцэг эхчүүд сургалт, өдөрлөг, болон эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан үйл ажиллагаануудад илүү оролцож байна.

Дээрх ажлуудаас гадна төслийн хүрээнд “Сургууль-Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй” сургалтын модульд багш-эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулах арга зүй, эцэг эхийн зөвлөлийг байгуулах арга зүй гэх мэт сургууль-багш-эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулах, идэвхи санаачилгыг дэмжих олон аргачлал, арга зүйг тусгасан байсан. Үүний үр дүнд зорилтот сургуулиуд дээр “Баруун гарын баталгаа”, “Жимс” гэх мэт арга зүй, “Миний хайртай хүмүүс”, “Хүндэт сандал” гэх мэт өөр олон шинэ санаачилгуудыг эцэг эхийн оролцоо, дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн туршлагауд байна.

Төслийн хүрээнд эцэг эхчүүдэд зориулан гаргасан “Сургууль-Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй” болон “Эцэг эх- Багштай харилцах дэвтэр”-тэй ажиллах арга зүй сургалтын модулиудын хүрээнд зорилтот сургуулийн эцэг эхчүүд сургууль, багш нарын хамтарсан олон үйл ажиллагаа шинээр нэвтэрсэн. Тухайлбал, “Эцэг эх- Багштай харилцах дэвтэр”, Эцэг эхийн зөвлөлийн багт хуваарилагдсан шинэ зохион байгуулалт, эцэг эхчүүдийн сургалт дахь оролцооны хэлбэр төрөлжсөн зэрэг олон үйл ажиллагааг сургууль, багш нар, эцэг эхийн хамтран хэрэгжүүлж эхэлсэн нь сургуулын удирдлагуудтай хийсэн ярилцлагаас харагдаж байлаа.

Эдгээр сургалтын модулиудад заасан аргачлалын хүрээнд эцэг эх-багш нарын хамтын ажиллагаа сайжирч, эцэг эхчүүд илүү зохион байгуулалттай болж, оролцоо нь нэмэгдсэн талаар Эцэг эхийн зөвлөлийн төлөөллүүд ярилцлагын үеэр нийтлэг дурдагдаж байлаа.

Өмнө жил эцэг эхчүүд 5 багт хуваагдсан. Багууд тус тусдаа ажилладаг байсан. Хамгийн ачаалалтай баг нь ахиц амжилтын баг байсан. Учир нь дөнгөж 1-р ангид орсон хүүхдүүд уншиж чадахгүй үсгээ цээжлэхэд нь ганц багш хүрэлцэхгүй. Тиймээс энэ баг 7 хоногт 2-3 удаа багшдаа тусалдаг байсан. Мөн оролцооны баг хүүхдүүдэд хэрэгтэй байгаа хэрэглэгдэхүүн, материалыг бэлтгэх гэх мэтээр ажилладаг байсан.

УБ. Чингэлтэй дүүрэг. Эцэг эхийн зөвлөлийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Төслийн хүрээнд бүх зорилтот сургуулиудын багш болон эцэг эхчүүд хамтран дээрх хоёр сургалтуудын модулийг зорилтот бус сургуулиудад танилцуулж, шинэлэг ажлууд, хамтын ажиллагааны хэлбэрүүдийг хэрэгжүүлсэн туршлагаа түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан. Төслийн 3 дүүргийн зорилтот сургууль тус бүр өөрийн харъяаны төсөл хэрэгжээгүй сургуулиудыг хариуцан авч туршлагаа түгээх ажлыг зохион байгуулсан байна.

Бусад үр дүн

Чанарын судалгааны үр дүнгээс харахад, төслийн зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн багштай хамтран ажиллах хэлбэр нь харилцах дэвтрээр харилцах, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, анги танхим тохижуулах, ‘Баруун гарын баталгаа’, ‘Манай гэр бүл’, ‘Би ирлээ ’ гэх мэт самбарууд ажиллуулах, эцэг эхчүүдийн сонирхол хөгжүүлэх багуудад хуваарилах гэх мэт олон төрөл хэлбэртэй болсон байна. Эдгээр төслийн модульд тусгагдсан шинэлэг арга, аргачлалыг нэвтрүүлснээр эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд эерэг үр дүнгээ өгсөн байна.

Үнэлгээнд хамрагдсан нийт зорилтот болон зорилтот бус сургуулиудын эцэг эхчүүдийн хувьд багшаас авч буй мэдээлэлд төдийлөн ялгаа ажиглагдахгүй байна. Зорилтот сургуулиудын эцэг эхчүүд багшаас гол төлөв хүүхдийн хичээлдээ оролцох оролцоо, сонирхол (97.8%), хүүхдийн биеэ авч яваа байдал, үйл хөдөлгөөн (93.0%), хамт олны дунд байхдаа харилцах харилцаа, зан байдал (90.5%)-н талаар мэдээлэл авч байна.

Харин зорилтот болон зорилтот бус сургуулийн СӨБ-д хамрагдаагүй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн хувьд ихээхэн ялгаа ажиглагдаж байна.


Дүрс 12. Эцэг эхийн багштай харилцан ярилцдаг асуудлууд (%)



Дээрх дүрсээс харахад зорилтот сургуулийн СӨБ-д хамрагдаагүй эцэг эхчүүд болон багш нарын харилцаа илүү ойр байна. Ялангуяа зорилтот сургуулийн эцэг эхчүүд хүүхдийн биеэ авч яваа байдал, үйл хөдөлгөөн ($t=14.089$, $p=0.000$) болон хүүхэд багш болон бусад хүмүүстэй харилцах харилцааны ($t=4.950$, $p=0.026$) талаар мэдээлэл авч буй байдал зорилтот бус сургуулийн эцэг эхчүүдээс мэдэгдэхүйц өндөр байна.

Үнэлгээнд хамрагдсан эцэг эхчүүдээс харилцах дэвтэр болон бэлтгэл хөтөлбөрийн агуулгад заасан дараах мэдээллүүдийг авсан эсэхийг тодрууллаа.

Дүрс 13. Эцэг эхчүүдийн багшаас авдаг мэдээлэл (“Тийм” гэж хариулсан хувь (%))



Дээрх дүрсэд үзүүлсэнчлэн төслийн суурь судалгаатай харьцуулахад багшаас ‘Бэлтгэл хөтөлбөр’, ‘аюулгүй байдлыг сахих’, ‘сургууль, ангийн шинэ орчны тухай мэдээлэл’, ‘нийгэмшихүйн чадвар’, ‘хүүхдийн ариун цэврийг сахих’-тай холбоотой мэдээллийг авч буй эцэг


эхчүүдийн хувь өссөн байна. Эдгээр агуулга бүхий мэдээллүүд нь төслийн хүрээнд боловсруулсан “Эцэг эх-Багштай харилцах дэвтэр”-тэй ажиллах арга зүй болон “Сургууль-Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй” сургалтын модулиудад орсон байдаг. Тиймээс эдгээр модулиуд нь зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн мэдлэг, мэдээлэлд эерэг өөрчлөлт бий болгосныг харуулж байна.

Зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн олонхи нь буюу 88.8 хувь нь анги удирдсан багшаас, 27.5 хувь нь ТВ, радиогоос, 20.9 хувь нь Эцэг эх-Багштай харилцах дэвтрээс, 17.8 хувь нь Ангийн эцэг эхийн зөвлөлөөс, 12.6 хувь нь Сургуулийн эцэг эхийн зөвлөлөөс тус тус мэдээлэл авч байна.

Зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн 92.4 хувь нь зорилтот бус сургуулийн эцэг эхчүүдийн 88.1 хувь нь хүүхдийн элсэлт болон сургуульд дасан зохицох талаар авсан мэдээлэл нь хэрэгцээ шаардлагад нийцсэн гэж хариулжээ. Мөн 1-р ангийн бэлтгэл хөтөлбөрт хамрагдсанаар суралцах, дасан зохицох чадварт үзүүлсэн нөлөөг үнэлүүлэхэд зорилтот сургуулийн эцэг эхчүүд (88.4%) зорилтот бус сургуулийн эцэг эхчүүдээс(82.5%) мэдэгдэхүйц($t=17.365, p=0.000$) эерэг хариулт өгчээ.


Төслийн хүрээнд боловсруулсан нэгдүгээр ангийн сурагчдыг сургуулийн амьдралд дасан зохицох, амжилттай суралцах чадварыг дээшлүүлэх зорилго бүхий “Эцэг эх-Багштай харилцах дэвтэр”-г төслийн зорилтот сургуулийн 1-3-р ангийн эцэг эхчүүдийн 74.0 хувь нь тодорхой хэмжээнд ашигласан байна.

Дүрс 14. Харилцах дэвтрийн ашиглалтын хувь (%)



“Эцэг эх-Багштай харилцах дэвтэр”-г ашиглаж буй эцэг эхчүүдээр уг дэвтрийг ашигласнаар гарсан өөрчлөлт, сурсан мэдлэг, чадварыг нээлттэй асуултуудаар тодруулсан. Зорилтот сургуулийн эцэг эхчүүд уг дэвтрийг ашигласанаар хүүхдийнх нь суралцах чадвар, бие даах чадвар, хичээл хийх арга барил болон багштай харилцах үр чадварууд сайжирсан гэж дүгнэжээ. Мөн түүнчлэн эцэг эхчүүд харилцах дэвтрийг ашигласнаар хүүхдийн хөгжлийн онцлог, хүүхэдтэй харилцах, хүүхдийг хөгжүүлэх, хичээлийг хийлгэх арга барил, багштай харилцах зэрэг шинэ мэдлэг, чадварт суралцсан талаар нийтлэг дурдаж байлаа.

Дүрс 15. “Эцэг эх-Багштай харилцах дэвтэр”-н хүүхдийн суралцах болон дасан зохицох чадварт үзүүлсэн дэмжлэг (%)



“Эцэг эх-Багштай харилцах дэвтэр”-ийг ашиглаж буй эцэг эхчүүдийн талаас илүү хувь нь (66.9%) уг дэвтрийг хүүхдийн суралцах болон дасан зохицох чадварт эерэг (маш сайн, сайн) үр дүн үзүүлсэн гэжээ.

Дээрх үр дүнгүүдээс харахад, төслийн зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн хувьд хүүхдийн суралцах болон дасан зохицох чадварын талаар мэдээлэл авч буй гол эх сурвалж нь анги удирдсан багш нар болж байна. Мөн зорилтот сургуулийн эцэг эхчүүд зөвхөн сурлагатай холбоотой мэдээлэл бус хүүхдийн нийгэмшихүй чадвар, аюулгүй байдал, хүүхдийн суралцах орчны талаар гэх мэт өргөн хүрээнд мэдээлэл авч байна. Ялангуяа төслийн онцлох ажил болж буй “Эцэг эх- Багштай харилцах” дэвтэр нь эцэг эх, багш хооронд мэдээлэл солилцох нэг хэрэгсэл болохоос гадна хүүхдийн суралцах болон дасан зохицох чадварыг сайжруулахуйц үр дүнтэй ажил болсон байна.

Үр дүнгийн үзүүлэлт 3.2

Үр дүнгийн үзүүлэлт 3.2:

Бүх зорилтот сургууль сургуулийн ажилтнууд болон эцэг эхчүүдийн дэмжлэг бүхий идэвхитэй эцэг эхийн зөвлөлтэй болж, өөрсдийн түршлагыг зорилтот бус сургуулиудад түгээдэг байх

Эцсийн үнэлгээний үзүүлэлт: Бүх (24)

Мэдээллийн эх сурвалж: Багш нарын асуумж

Гол үр дүн

2017 оны 12-р сарын байдлаар төсөлд хамрагдсан **24 зорилтот сургууль** 1-р ангиудын эцэг эхийн зөвлөлийг байгуулан, үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна.

Сургуулийн удирдлагуудтай хийсэн ярилцлагаас харахад, төсөл хэрэгжээгүй зорилтот дүүргийн бусад сургуулиудад мэдлэг, түршлага түгээх ажлыг сургалт, өдөрлөг хэлбэрээр хүргэсэн байна. Эдгээрээс гадна зорилтот сургуулийн эцэг эхийн зөвлөлүүд хоорондоо болон шинээр бүрдэж буй 1-р ангийн эцэг эхийн зөвлөлтэй түршлага, мэдээлэл солилцон ажиллаж байна. Тухайлбал, 37-р сургууль, 117-р сургууль, Шавь цогцолбор, 79-р сургууль гэх мэт сургуулиуд сургууль дотроо анги, бүлгийн Эцэг эхийн зөвлөл хооронд өөрсдийн үйл ажиллагааны түршлага солилцох уулзалт, ажлуудыг зохион байгуулжээ.

Бусад Эцэг эхийн зөвлөлтэй туршлага солилцох үйл ажиллагаа болсон. Эцэг эхчүүдийн багаас явуулсан үйл ажиллагаагаа тайлагнаж, танилцуулсан. Багш ярихаас илүүтэйгээр эцэг эхчүүд хоорондоо ярилцаж зөвлөлдсөн нь илүү үр дүнгээ өгсөн.

УБ. Чингэлтэй дүүрэг. Эцэг эхийн зөвлөлийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Эцэг эхийн зөвлөлийн туршлага солилцох үйл ажиллагаа их ач холбогдолтой байсан. Туршлага солилцох үйл ажиллагаагаар оролцооны модны талаар яг сайн ойлгодоггүй байсан бол сайн ойлголттой болж түүнийг ангидаа хэрэгжүүлээд эцэг эхчүүдийн оролцоо эрс нэмэгдсэн.

УБ. Баянзүрх дүүрэг. Эцэг эхийн зөвлөлийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Дээрх төслийн хүрээнд зорилтот бүх сургуулиуд эцэг эхчүүдэд зориулсан сургалтын модулийг танилцуулах, шинэ аргачлалууд ашигласан туршлагаа хуваалцах, сурталчлах, үйл ажиллагаагаа тайлагнах хэлбэрээр түгээх ажлуудыг гүйцэтгэсэн байна. Тиймээс зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн төлөөлөл болж буй Эцэг эхийн зөвлөлүүдийг өөрсдийн мэдлэг, туршлагаа түгээх туршлагатай болсон дүгнэж болохоор байна.


Мөн эдгээрээс гадна, төсөл хэрэгжиж эхлэсэн цагаас хойш хамрагдсан зорилтот сургуулиудын 2, 3-р ангийн эцэг эхийн зөвлөл үйл ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлж байгаа нь чанарын судалгаанд дурдагдаж байсан.

Бусад үр дүн

Үнэлгээнд хамрагдсан эцэг эхчүүдээр ‘Сургууль-Багш-Эцэг Эх’-н хамтын ажиллагааг үнэлүүлэхэд зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн олонх (80.4%) нь эерэг (маш сайн, сайн) үнэлгээ өгсөн байна. Харин зорилтот бус сургуулийн эцэг эхчүүд 74.9 хувь нь эерэг үнэлгээ өгчээ. Чанарын судалгааны үр дүнд, эцэг эх-багш хооронд мэдээлэл солилцоо нэмэгдсэн, эцэг эхчүүдийг багт хувааж ажиллуулж хамтын ажиллагаа, оролцоог нь сайжруулсан, эцэг эхчүүдийг идэвхжүүлэх, оролцуулах санаачилгууд нэмэгдсэн зэрэг нийтлэг шалтгаануудыг дурдсан байна.

Эцэг эхчүүдээс хүүхдийнхээ анги, бүлгийн эцэг эхийн зөвлөлийн талаар мэдэж буй эсэхийг тодруулахад зорилтот сургуулийн эцэг эхчүүд (94.0%)-ийн оролцоо, мэдлэг нь зорилтот бус бүлгийн (86.0%) эцэг эхчүүдээс мэдэгдэхүйц өндөр байна ($t=15.242, p=0.000$).

Дүрс 16. Эцэг эхийн зөвлөлийн талаар мэдэж буй эцэг эхийн хувь (%)



Дээрх үр дүнгээс харахад төслийн зорилтот сургуулиудын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа илүү идэвхтэй ажиллаж байгаа нь харагдаж байна.

Мөн зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн 84.2 хувь нь хүүхдийнхээ ангийн эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эерэгээр (маш, сайн) гэж үнэлсэн байна. Харин зорилтот бус бүлгийн эцэг эхчүүдийн хувьд эерэг үнэлгээ нь (56.6%) мэдэгдэхүйц бага байна.

Эцэг эхчүүдээс авсан чанарын мэдээллийн хүрээнд зорилтот сургуулийн эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд өгсөн эерэг үнэлгээний шалтгааныг тодруулахад


- Хүүхдийн сурах орчинг сайжруулах чиглэлээр ажил хийдэг
- Багштай хамтарч тогтмол үйл ажиллагааг зохион байгуулдаг
- Эцэг эхчүүд баг болж ажилладаг учраас нэгдсэн зохион байгуулалт, багаараа ажиллах чадвар сайтай
- Багш-эцэг эхчүүдийн харилцаа ойр бөгөөд тогтмол
- Багшийн заах хичээлийн хүрээнд шаардлагатай, хүүхдийн сурч боловсрол тал дээр илүү их анхаарсан ажил хийдэг гэсэн олон төрлийн шалтгааныг дурджээ.

Харин зорилтот бус сургуулийн эцэг эхээс өөрсдийнх нь эцэг эхийн зөвлөлийг сайн үнэлсэн шалтгааныг тодруулахад эцэг эхийн оролцоо идэвх сайн гэдгээс өөр онцлог жишээ, шалтгаан дурдаж чадаагүй байна. Энэ нь зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн зөвлөлийн үйл ажиллагаа нь илүү үр өгөөжтэй, үүнд өгсөн эцэг эхчүүдийн үнэлгээ нь илүү бодитой байгааг харуулж байна.

Мөн түүнчлэн зорилтот сургуулийн багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагын үеэр багш нар эцэг эхийн зөвлөл нь сургуулийн бодлого, үйл ажиллагаанд оролцдог болсон, эцэг эхийн зөвлөл эрүүл мэнд, ахиц дэвшил, төлөвшил гэх мэт 5 багт хуваагдсанаар чиглэл бүрийн дагуу ажлуудаа явуулдаг болсон зэрэг онцлог өөрчлөлтийг нэрлэж байлаа.

Мөн багш нараар эцэг эхийн оролцоог үнэлүүлэхэд зорилтот сургуулийн багш нар эцэг эхчүүддээ мэдэгдэхүйц эерэг үнэлгээ өгсөн байна.

Дүрс 17. Эцэг эхчүүдийн оролцооны үнэлгээ, 'сайн' гэсэн хариулт өгсөн хувиар (%)



Дээрх үр дүнгээс харахад, зорилтот сургуулийн багш нар нар эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагаа сайн байна.

Сургуулийн удирдлага, багш нар болон эцэг эхийн зөвлөлтэй хийсэн ярилцлагын үеэр мөн төслийн хамгийн үр дүнтэй, сайн түршлага бүхий ажил нь эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа байсныг нийтлэг дурдаж байлаа.

...1-р ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн уламжлалт ажлуудаас ялгаатай, хамгийн үр дүнд хүрсэн шинэлэг ажлууд нь эцэг эхийн зөвлөл байгуулах аргачлал, эцэг эхчүүдийг багуудад хуваах, үйл ажиллагаанд татан оролцуулах, идэвхижүүлэх аргачлалууд байсан. Үүнтэй холбоотойгоор эцэг эхийн зөвлөл сонгох тухай сургалт хурлууд зохион байгуулж, өөрсдийн санаачилгаар, сайн дураар далайцтай ажил хийх болсон.

УБ. Баянзүрх дүүрэг. Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас

...Сургалтын менежертэй хамт төлөвлөгөө боловсруулаад батлуулаад амжилттай хэрэгжүүлсэн. Багаар ажиллах явцыг идэвхижүүлж байгаа. Ахиц дэвшлийн баг, төлөвшилийн баг, эрүүл мэндийн баг гэх мэт багуудад хуваагдсан. Тухайлбал, гарын жижиг булчингууд хөгжүүлэх зорилгоор хүүхдүүдийн дунд шагай наадгайг хөгжүүлэе гээд "Шагай наадгай" гээд тэмцээн зохиосон. Мөн хүүхдийг сургуулийн орчинд дасан зохицуулах үйл ажиллагаа, хүүхдийг хэрхэн идэвхижүүлэх тал дээр мөн манай сургуулийн менежер болон 1-5-р ангийн эцэг эхчүүдийн дунд сургалтууд зохион байгуулсан.

УБ. Чингэлтэй дүүрэг. Эцэг эхийн зөвлөлийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Мөн зорилтот сургуулийн эцэг эхийн зөвлөлөөс бусад сургуулийн эцэг эхийн зөвлөлд түршлагаа солилцох арга хэмжээ явуулж байгаа нь шинээр сурсан арга аргачлал, үйл ажиллагааны хэлбэрийг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулжээ.

Төслийн зарим зорилтот сургуулийн эцэг эхийн зөвлөлөөс өөрсдийн үйл ажиллагаа, сайн түршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор бусад ангийн болон бусад зорилтот бус сургуулийн эцэг эхийн зөвлөлүүдийн дунд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж байжээ.

Ерөнхийдөө эцэг эхчүүдэд чиглэсэн үйл ажиллагаа нь хамгийн үр дүнтэй, ихээхэн эерэг өөрчлөлт авчирсан ажил болсон нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Ялангуяа, төсөл хэрэгжсэний дараа эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа нь илүү идэвхтэй, бүх эцэг эхчүүдийг хамруулсан хэлбэрээр, илүү зохион байгуулалттай явагдаж байна.

...Бусад анги, сургуулиудад багт хуваан ажиллуулах, танилцах аялал зохион байгуулах, зангиа, тууз энгэрийн тэмдэгээр ижилсэх гэх мэт сайн түршлагаа түгээх сургалтууд орсон. Их сайхан хүлээж авсан. Түршлага солилцох үйл ажиллагаагаар сайн ойлголттой болж түүнийг ангидаа хэрэгжүүлээд эцэг эхчүүдийн оролцоо эрс нэмэгдсэн.

УБ. Чингэлтэй дүүрэг. Эцэг эхийн зөвлөлийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа нь багш, сургуулийн сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээс гадна, хүүхдийн суралцах чадварт ихээхэн эерэг нөлөө үзүүлж байна.

4.4. Нөлөөлөл

Энэхүү дэд бүлэгт төслийн Зорилт 4 буюу “Төслийн үр дүнд амжилттай хэрэгжсэн загвар, үйл ажиллагааг сурталчлах, төрийн бодлогод тусгах” ажлын хүрээнд хийгдсэн ажлын үнэлгээний үр дүнг танилцуулна.

Энэ бүлэг дурдсан үр дүн судалгаанд хамрагдсан сургуулийн сургуулийн удирдлага, менежерүүд, дүүргийн боловсролын мэргэжилтэн, БСШУСЯ-ны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагуудад суурилсан болно. Төслийн зорилтын хүрээнд хийгдсэн ажлын үр нөлөөг төслийн баримт бичигт дурдсан хоёр шалгуур үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлжээ.

Үр дүнгийн үзүүлэлт 4.1:

Төслийн Удирдах Зөвлөлийн 12 гишүүн байгууллагуудаас хамгийн багадаа 6 байгууллага нь (БСШУСЯ, БМДИ, МУБИС, Нийслэл, 3 Дүүргийн Боловсролын Хэлтэс зэрэг) өөрийн үйл ажиллагаагаа төслийн үйл ажиллагаатай холбон ажилласан байх.

Эцсийн үнэлгээний үзүүлэлт: 6 байгууллага

Мэдээллийн эх сурвалж: Төслийн жил тутмын тайлан, ярилцлагууд

Гол үр дүн.

Төслийн үе шатуудад төслийн зорилтуудын хүрээнд 6 гол хамтран ажиллагч талуудтай дараах үйл ажиллагаануудыг хамтран шийдвэрлэж, гүйцэтгэсэн байна. Үүнд:

7. БСШУСЯ:

- БСШУСЯ-наас 2017 оны А/226 дугаар тушаалаар “Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөр”-ийг баталгаажуулж улсын хэмжээнд мөрдүүлснээр төслийн үр дүнг үндэсний түвшинд түгээн дэлгэрүүлэхэд чухал алхам болсон байна.
- БСШУСЯ-ны сурах бичгийн стандартад нийцүүлэн Бэлтгэл хөтөлбөрийн “Дасгал ажлын дэвтэр”-г боловсруулж түрших, засан сайжруулах ажлууд хийсэн. Улмаар 2017-2018 оны хичээлийн жилд БСШУСЯ-ны улсын төсвийн хөрөнгөөр хэвлүүлэх “Сурах бичгийн нэгдсэн жагсаалт”-д оруулж батлуулсан ба тус хичээлийн жилд ЕБС-ийн 1-р ангийн нийт 73,545 хүүхдэд “Дасгал ажлын дэвтэр” түгээж, бэлтгэл хөтөлбөрийн сургалтад ашиглажээ.
- БСШУСЯ-ны “Боловсролын Удирдлага Мэдээлийн Систем (БУМС)”-д “Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах арга зүй” (төслийн модуль 1.2) модулийн 1, 2-р бүлгийн хүүхдийн талаар мэдээлэл цуглуулах асуулгуудыг нэгтгэж оруулсан. Мөн уг системийн судалгааны модулийн хэсэгт 4-р бүлгийн “хүүхдийн хөгжил чадварын ахиц”-ын мэдээлэл цуглуулах асуулгуудыг оруулсан. Энэхүү асуулгаар цуглуулсан мэдээллийг БУМС-д хэрхэн оруулах практик сургалтыг БСШУСЯ-тай хамтран сургуулийн менежер, секцийн ахлагч багш нарт зориулан 2 удаа зохион байгуулсан. Үүнийн үр дүнд нэгдсэн мэдээллийн системд сургуулийн түвшинд цуглуулсан мэдээллээ оруулах, мэдээлэл татаж авах, дүн шинжилгээ хийх талаар зохих чадвар түршлага хуримтлуулж байна.
- БСШУСЯ нь Улаанбаатар хотын 9 дүүрэг болон 21 аймгийн 36 мэргэжилтэнд төслийн модулиудыг танилцуулах сургалт зохион байгуулсан.

8. Нийслэлийн Боловсролын Газар:

- Нийслэлийн Боловсролын Газраас Улаанбаатар хотын нэгдүгээр ангийн нийт 580 багш нарт сургалт зохион байгуулсан. 2016-2017 оны хичээлийн жилд зорилтот сургуулиудын 60 багш 20 бүлэгт хуваагдан өөрсдийн дадал, туршлагыг нийслэлийн 1-р ангийн 800

гаруй /зорилтот бус сургууль/ багш нартай хуваалцсан байна. Энэхүү туршлагад үндэслэн ирэх хичээлийн жилд нэгдүгээр ангийн багшнарт зориулан ижил төрлийн сургалтыг зохион байгуулахаар НБГ-н сургалтын агуулгад тусгаж өгсөн байна.

9. Нийслэлийн Хүүхэд, Гэр бүл хөгжлийн газар:

- НХГБХГ нь Улаанбаатар хотын бүх дүүргийн Хүүхэд, Гэр бүл хөгжлийн газрын мэргэжилтнүүдийг сурган, тэдгээрээр дамжуулан Эцэг эхийн зөвлөлийн загварыг түгээн дэлгэрүүлж сургуульд бэлтгэгдсэн байдал болон дасан зохицох чадвар дахь гэр бүлийн дэмжлэгийг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

10. Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС):

- МУБИС-ийн багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн заавал судлах “Боловсролын сэтгэл зүй II” хичээлийн агуулгад “Сургуулийн өөрийн үнэлгээ”, “Эцэг эхтэй ажиллах арга зүй” модуль сургалтуудын мэдээллийг 2 цагаар орохоор тусгасан.
- Мөн төслийн модуль сургалтын агуулгыг тогтвортой хадгалан цаашид ашиглах зорилгоор МУБИС-ийн Багшийн сургуульд жишиг анги байгуулан төслийн сургалтын материал, хэрэгслүүдээр хангасан байна. МУБИС-ийн Сургуулийн Өмнөх Боловсролын сургуультай хамтран “Хүүхдийн хувийн мэдээллийг ашиглах арга зүй” (модуль I) сургалтыг зохион байгуулж төслийн 2 дахь шатанд сонгогдсон 12 сургуулийн сургалтын менежер, багш нар үндсэн сургалтад хамрагдсан байна.

11. Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институт (БМДИ):

- БМДИ-тэй хамтран модуль сургалтын хөтөлбөрийг боловсруулах, үндсэн сургалтуудыг зохион байгуулах, гарын авлагыг боловсруулахад хамтран ажилласан. Үүний үр дүнд зорилтот сургуулиуд чанартай гарын авлага, хэрэглэгдэхүүнээр хангагдах, сургалтууд үр дүнтэй зохион байгуулах, төслийн үр нөлөөг дээшлүүлэхэд мэргэжлийн оролцоог бий болгосон байна.
- БМДИ төслийн сургалтын модулиудыг албан ёсоор магадлан итгэмжилсэн. Үүний үр дүнд төслийн сургалтын таван модулийг багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад ашиглах боломж бүрдсэн байна.

12. Боловсролын Хүрээлэн:

- Боловсролын Хүрээлэнтэй хамтран төслийн баг мэргэжлийн зөвлөх үйлчилгээг авах, модуль сургалтуудыг удирдан явуулах, сургалтын гарын авлага боловсруулах, шинэчлэх чиглэлээр дэмжлэг аван хамтран ажилласан байна. Тухайлбал нэгдүгээр ангийн “Бэлтгэл хөтөлбөр”-т зориулан “Дасгал ажлын дэвтэр”-г шинээр боловсруулахад Боловсролын Хүрээлэнгийн мэргэжилтнүүд зөвлөхөөр ажиллажээ.

Бусад үр дүн

Төслийн суурь бүтцийг бий болгох ажлын хүрээнд хамтран ажиллах байгууллагуудын төлөөллүүдээс бүрдэх Төслийн удирдах зөвлөл, зорилтот сургуулиудын төлөөллүүдээс бүрдэх 100 гаруй хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг байгуулан ажилласан байна.

Төслийн хүрээнд БСШУСЯ, Нийслэлийн Боловсролын Газар, Дүүргүүдийн Боловсролын Хэлтэс, Боловсролын Хүрээлэн, МУБИС-ийн Багшийн сургуультай дараах байдлаар хамтран ажилласан.

Дүрс 18. Төслийн хамтын ажиллагаа, хэрэгжилтийн үе шатаар

1-р үе шат:

- Төслийн төлөвлөлт, аргачлал, бүтцийг бий болгох, боловсруулах
- Сургалтын модулиуд боловсруулах
- Зорилтот дүүрэг, эхний 1-р үе шатанд хамруулах сургуулийг сонгох
- Сүүр судалгаа хийх
- Зөвлөх үйлчилгээ авах

2-р үе шат:

- Сургалтын модуль шинэчлэх
- Зөвлөх үйлчилгээ авах
- Хамтын ажиллагааг хөгжүүлэх, уялдааг сайжруулах

3-р үе шат:

- Туршлага солилцох /бусад сургуулиудад танилцуулах, түгээн дэлгэрүүлэх
- Боловсролын мэдээллийн санд холбогдох мэдээлийг тусгах
- Сүрах бичгийн жагсаалтад оруулах

4-р үе шат:

- Төслийн эцсийн үнэлгээ хийх
- Төрийн бодлого, зохицуулалтад тусгах, сурталчлах
- Туршлага солилцох үүлзалт, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа

Төслийн 2 дахь шатанд зорилтот сургуулиудын дунд туршлага солилцох үүлзалтуудыг зохион байгуулан төслийн үйл ажиллагааны үр дүн, сайн туршлага, сургамж, цаашид сайжруулах үйл ажиллагаа, хамтын ажиллагааны талаарх туршлага, саналаа хуваалцсан ба энэ арга хэмжээнд 184 багш, захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтнууд оролцсон байна.

Төслийн модуль сургалтаар амжилттай хэрэгжүүлсэн сайн туршлагаасаа хуваалцан багш, эцэг эхчүүдийн бүтээсэн сургалтын хэрэглэгдэхүүн, материалуудын үзэсгэлэн гаргасан байна.

Мөн сургууль-цэцэрлэгийн хамтарсан үүлзалтыг төслийн 2 дахь үе шатанд зорилтот 24 сургуульд зохион байгуулсан байна. Энэ үүлзалтад зорилтот сургуулиудын хамтран сургах тойргийн цэцэрлэгүүд хамрагдсан ба сургууль, цэцэрлэгүүд намар сургуульд элсэн орох 6 настай хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдал, суралцах чадварыг дэмжиж чиглэлээр

165, 67, Ирээдүй цогцолбор 2-р сургуулиудтай хамтран ажилладаг. Өмнө тэдгээр сургуулиудаас туршлага судалдаг байсан бол төсөлд хамрагдсанаар эргээд тэдгээр сургуульдаа туршлагаа түгээж ажиллаж байна. "2 туршлага-Нэг сургууль" аян явуулж "Ирээдүй" цогцолбор 2-р бага сургуульд түгээн дэлгэрүүлж байгаа. Хөдөөний сургуулиуд ирж туршлага судална. Төсөлд хамрагдсанаар ажлын туршлагатай болсон. Манай захын хорооллын сургууль гэдэг асуудлаас гарсан. Манай үйл ажиллагаа төвийн сургуулиас дутах зүйл байхгүй.

УБ. Сонгинохайрхан дүүрэг, Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас

хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах талаар хэлэлцсэн байна. Энэ үүлзалтад сургуулийн сургалтын менежер 23, бага ангийн багш 71, цэцэрлэгийн эрхлэгч 7, цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн багш 77, арга зүйч 14, нийт 197 хүн оролцсон байна.

Төслийн баг төслийн хэрэгжилтийн 2, 3 үе шатуудад нийгмийн сүлжээг ашиглан зорилтот сургуулиудад зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаа, хамтрын ажиллагаа, сайн туршлага, үр дүн, мэдээллийг багш, сургуулийн удирдлага, олон нийтэд түгээх ажлыг өрнүүлсэн байна.

Хүснэгт 14. Төслийн нөлөөллийн үйл ажиллагаанд нийгмийн сүлжээг ашигласан байдал

Мэдээллийн хэрэгсэл	ҮЙЛ АЖИЛЛАГАА
FACEBOOK	ХИС-ийн facebook-ээр 1-р ангийн хүүхдүүдийг сургуульд бэлтгэх, дасан зохицох талаарх мэдээллүүдийг 'live', post хийн хүргэсэн ба 350,000 мянга гаруй хүнд хүрсэн байна. https://www.facebook.com/pg/www.savethechildren.mn/about/
TV/ YOUTUBE	Төслийн танилцуулга, үйл ажиллагааг олон нийтэд хүргэх зорилгоор TV болон YouTube-ээр танилцуулах ажлуудыг хийсэн байна. Эдгээр мэдээллээр дамжуулан зорилтот сургуулиуд болон төслийн үр шим хүртэгчид болох багш, сургуулийн удирдлага, эцэг эхчүүд, олон нийтийг хүүхдийг сургуульд бэлтгэх, суралцах чадварыг дэмжих, хамтын ажиллагаа өрнүүлэх, улам боловсронгуй болох чиглэлээр мэдээлэл түгээсэн байна. https://www.youtube.com/watch?v=ZUDno0fwGcE ; https://www.youtube.com/watch?v=mciqQuQngVs
NEWSLETTER	ЯХИС төслийн үйл ажиллагааны мэдээллийг хүргэх зорилгоор мэдээллийн хуудсыг Монгол, Англи хэлээр бэлтгэн 9 дугаарыг хэвлэн тараасан байна. https://savethechildren.mn/uploads/publication/201711/2_newsletter_mon.pdf
Вэб сайт	Төслийн үе шатуудад төслийн танилцуулга, модуль сургалтуудын үйл ажиллагаа, үр дүн, зар мэдээлэл, хамтын ажиллагааны санал зэрэг мэдээллийг олон нийтийн сайтуудыг ашиглан түгээсэн байна. http://vip76.mn/content/33841 http://news.gogo.mn/r/169475

Төслийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, төслийн үр шим хүртэгчид үзүүлж байгаа үр нөлөөг сурталчлах зорилгоор хэвлэмэл постер, сонинд нийтлэл хэвлүүлэх, төслийн вэб сайтад мэдээлэл тавих, олон нийтийн телевизүүдээр мэдээлэл түгээх ажлуудыг зохион байгуулсан байна.

4.5. Бусад

Энэхүү дэд бүлэгт төслийн хамааралтай байдал, хамтын ажиллагаа, үр нөлөө, тогтвортой байдал/сайн туршлага гэсэн үнэлгээний үндсэн асуултуудын үр дүнг танилцуулна.

Энэхүү дэд бүлгийг суурь судалгааны үр дүн болон эцсийн үнэлгээнд хамруулсан зорилтот сургуулиудын удирдлагатай хийсэн ярилцлага, багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлага болон эцэг эхийн зөвлөлийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын мэдээлэлд суурилан боловсруулсан.

4.5.1. Хамааралтай байдал

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 02 дугаар сарын 03 -ны өдрийн 31 дүгээр тогтоолоор “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021)¹⁵ баталсан. Уг хөтөлбөрийн Стратегийн зорилт 1-ийн хүрээнд зургаан настай хүүхдийн сургуульд бэлтгэх стандартыг мөрдөж түүний хэрэгжилтийг хангахад эцэг эх, олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, зургаан настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйг боловсронгуй болгох талаар арга хэмжээ хэрэгжүүлэх талаар заасан.

Эдгээр ажлын хүрээнд БСШУСЯ-аас Нэгдүгээр ангийн сурагчдын “суралцах чадвар”-ыг дээшлүүлж, бага боловсролын сургалтын чанарыг хангахын тулд хичээлийн жилийн эхэнд сургуульд бэлтгэх хөтөлбөрт зориулан 80 цагийг гаргаж өгсөн. Гэвч 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн бэлтгэл хөтөлбөрийн цагийг 60 болгон бууруулсан ба түүний агуулга нь Монгол хэл, тоо бодлого зэрэг үндсэн хичээлийн давтлага төдийгөөр хязгаарлагдаж байжээ. Үүнээс гадна, төслийн хүрээнд 2015 онд хийсэн суурь судалгааны үр дүнгээс харахад нэгдүгээр ангийн багш нарын сурагчдын дасан зохицох болон суралцах чадварын талаарх мэдлэг дутмаг, уг чадварыг хөгжүүлэх хэрэглэгдэхүүн хүртээмжгүй байсан. Мөн нэгдүгээр ангийн сурагчдын эцэг эхчүүдийн оролцоо бага, эцэг эх-багш-сургуулийн хамтын ажиллагаа дутмаг, сургуулийн орчинд зургаан настай хүүхдийг хүлээн авах ээлтэй орчин бүрдээгүй байсан. Өөрөөр хэлбэл, зургаан настай хүүхдийг сургуульд бэлтгэхэд эцэг эх, багш, сургууль болон бодлогын түвшинд олон асуудал байсныг харуулж байна.

Энэхүү төсөл нь “Сургуульд дасан зохицох хөтөлбөр”-ийн тусламжтайгаар сонгосон төрийн өмчийн сургуулиудын 1-р ангийн сурагчдын суралцах чадварыг дээшлүүлэх зорилготой. Энэхүү зорилгын хүрээнд дээр дурдагдсан багш, сургууль, эцэг эх, бодлогын түвшинд тулгамдсан гол асуудлуудыг шийдвэрлэхээр зорьж ажиллажээ.

Суурь судалгааны үр дүнгээс харахад төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө багш нарт чиглэсэн сурагчдын дасан зохицох чадвар болон суралцах чадварын талаар сургалт дутмаг байсан. Багш нарын ачаалал их, эцэг эхчүүд, бусад талуудын хамтын ажиллагаа дутмаг учраас сурагчдад таатай орчин бүрдүүлэх, сургалтын шинэлэг арга зүй, хэрэглэгдэхүүн хийх, ашиглах боломж дутмаг байжээ. Мөн хүүхдийн хөгжлийн талаарх мэдээллийг багш бүр өөр өөр хэлбэрээр, өөр түвшинд цуглуулж байна. Гэхдээ ихэвчлэн уламжлалт цаасан хэлбэрээр мэдээлэл цуглуулдаг ч, түүнийг ашигладаг, мэдээллээ тогтмол шинэчилдэг дадал сул байв. Төслийн зорилт 1 нь “Багш нарын чадавхийг дээшлүүлэх”-н хүрээнд багш нарт зориулсан суралцах чадварын талаарх мэдлэг ойлголттой болох, сурагчдын суралцах чадварыг сайжруулахад ашиглах аргачлал, арга зүйг тусгасан модулиудыг боловсруулсан. Тухайлбал, хүүхдийн хөгжлийн мэдээллийг цуглуулах, ашиглах дэвшилтэт аргачлал, суралцах чадварыг хөгжүүлэхэд ашиглах сургалтын

¹⁵<http://www.legalinfo.mn/annex/details/2599?lawid=8138>

хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүй, сургалтын аргачлалуудыг эдгээр модулиудад тусгаж өгсөн. Мөн эцэг эх болон бусад багш, ажилтнуудыг хэрхэн оролцуулах талаар сургалтууд хийгдсэн. Дээрх үйл ажиллагаануудаас харахад багш нар суурь судалгааны үр дүн болон түүнд суурилан боловсруулсан санал зөвлөмжийг үйл ажиллагаанд бүрэн харгалзан үзсэн байна. Өөрөөр хэлбэл багш нарт тулгамдаад байсан нэн тэргүүний бэрхшээлүүдийг шийдвэрлэх чиглэсэн ажил болжээ.

Суурь судалгааны үр дүнгээс харахад, эцэг эхийн хүүхдийн суралцах чадвартай холбоотой мэдлэг, чадвар хангалтгүй байсан. Мөн түүнчлэн эцэг эхчүүдийн оролцоо, санаачилга бага, сургууль, багш нарын зүгээс эцэг эхчүүдэд чиглэсэн ажил дутмаг байснаас багш-эцэг эх-сургуулийн хамтын ажиллагаа төдийлөн идэвхтэй биш байсан. Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа нь тогтмол бус байхаас гадна эцэг эхийн зөвлөлийн хурал, анги танхим тохижуулах гэх мэт уламжлалт ажлуудаар хязгаарлагддаг байжээ¹⁶. Ялангуяа төслийн зорилтот сургуулиудын сурагчдын эцэг эх нь боловсролын түвшин бага, орлого багатайгаас шалтгаалан хүүхэдтэй харилцах, хүүхдийн хөгжлийн дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа дутмаг явуулдаг байна. Төслийн зорилт 3 нь *‘Хүүхдийн суралцах чадварыг дэмжих талаар эцэг эх/асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлууд зохион байгуулах’* байсан. Энэхүү зорилтын хүрээнд “Эцэг эх-Багштай харилцах дэвтэртэй ажиллах арга зүй” болон “Сургууль-Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй” гэсэн хоёр төслийн модулийг тусгайлан боловсруулсан. Эдгээр модуль болон бусад аргачлал, хэрэглэгдэхүүнээр дамжуулан эцэг эхчүүдийн суралцах чадварын талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах цуврал сургалтууд, эцэг эх-багш хооронд хүүхдийн хөгжлийн талаар мэдээлэл солилцох “Харилцах дэвтер”-г боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор, багш нар болон эцэг эхийн дунд модулийн сургалтуудыг зохион байгуулсан. Мөн эцэг эхчүүдийг сонирхлын багуудад хуваан, зохион байгуулалттай, төлөвлөлттэй ажиллаж, олон төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх туршлагыг нэвтрүүлсэн. Үүний хүрээнд, хүүхдийн хөгжилд чиглэсэн тэмцээн, аян зохион байгуулах, хүүхдийн суралцах, дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхэд нь зориулж сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, ангийг нь тохижуулах зэрэг олон төрлийн үйл ажиллагааг нэвтрүүлэхэд нь арга зүйн зөвлөмж өгч ажиллаж байна. Энэхүү зорилтын хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа нь суурь судалгааны үр дүнд дурдагдсан эцэг эхчүүд, эцэг эхчүүдийн зөвлөл болон эцэг эх-сургуулийн хамтын ажиллагаанд тулгамдсан асуудлуудыг шийдэхэд чиглэжээ. Тухайлбал, суурь судалгааны санал зөвлөмжид дурдсан эцэг эхчүүдийн ойлголт, мэдлэгийг сайжруулах, идэвх оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлуудыг гүйцэтгэсэн нь зорилтот сургуулийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц ач холбогдолтой байсныг илтгэж байна.

Дээрх бүх ажлууд нь энэхүү төслийг үндэсний хэмжээний стратеги зорилтыг дэмжсэн, сургууль, багш нар, эцэг эхчүүдийн дунд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхүйц бодитой, нотолгоонд суурилсан, ач холбогдолтой байсныг батлан харуулж байна.

4.5.2. Хамтын ажиллагаа

“Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхийг бэхжүүлэх” нь төслийн хүрээнд төрийн байгууллага, сургууль, хороо, цэцэрлэг гэх мэт олон тооны байгууллага, хувь зөвлөхүүдтэй хамтын ажиллагаа бий болгожээ.

¹⁶Суурь судалгаа, 2015, IRIM судалгааны хүрээлэн

Төсөл хэрэгжиж эхлэмэгц 2015 оны 6 сард БСШУСЯ-тай Харилцан ойлголцлын санамж бичиг зурсан. Мөн төслийн бодлогын түвшинд арга зүйгээр хангах, боловсролын салбарын гол оролцогч талуудын дунд нягт хамтын ажиллагааг бий болгох зорилго бүхий Төслийн удирдах зөвлөлийг байгуулсан. Уг зөвлөл нь Монгол улсын боловсролын их сургууль, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Нийслэлийн боловсролын хэлтэс, Дүүргүүдийн боловсролын хэлтэс гэх мэт төслийн хэрэгжилтэд шууд нөлөөлөх оролцогч талуудын төлөөлөл бүхий 12 гишүүдээс бүрдсэн. Үүнээс гадна, төслийн зорилтот дүүргийн боловсролын хэлтсийн мэргэжилтнүүд болон зорилтот сургуулийн удирдлага болон сургалтын менежерүүд, тэргүүлэх багш зэргээс бүрдсэн 100 орчим гишүүнтэй ажлын хэсгийг байгуулсан.

Төслийн хүрээнд БСШУСЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгийн багш, сургагч, зөвлөхүүдтэй хамтран сургалтын модулиудыг боловсруулсан. Боловсруулсан сургалтын модулиуд дээр БСШУСЯ, дүүрэг, нийслэлийн боловсролын мэргэжилтнүүдээс санал авч сайжруулан эцэслэсэн. Мөн сургууль болон оролцогч талуудын саналын дагуу сайжруулах ажлыг жил тутам зохион байгуулсан.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд, зорилтот сургуулиудад “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр”-г хэрэгжүүлэх зорилгоор сургуулийн удирдлага, багш нараас гадна сургуулийн бусад ажилтнууд болон сургуулийн өмнөх боловсролын багш нарыг хамруулж хамтын ажиллагааг эхлүүлсэн. Мөн түүнчлэн, төслөөс сургуулиудад сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор хороо, цэцэрлэг, цагдаа гэх мэт талуудтай хамтран ажиллах талаар удирдамж өгсөн. Үүний дагуу зорилтот сургуулиуд нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэгтэй хамтран ажиллах талаар хэлэлцүүлэг, уулзалтуудыг зохион байгуулсан. Эдгээр ажлын үр дүнд багш нар төслийн хүрээнд шинээр сурсан арга зүй, аргачлал болох хүүхдийн хөгжлийн мэдээлэл солилцох зорилгоор цэцэрлэгийн багш нартай шинээр хамтран ажилладаг болсон байна. Мөн 1-р ангийн сурагчдын бүртгэл мэдээллийг хорооны бүртгэл мэдээллээс авч, зорилтот хүүхдүүдийг тодорхойлж, сургуультай танилцах аялал хийх, СӨБ-д хамрагдаагүй хүүхдүүдийг зун хичээл эхлэхээс өмнө Бэлтгэл хөтөлбөрт хамруулах зэрэг шинэлэг хамтын ажиллагааг эхлүүлсэн байна.

Төслийн нэгдүгээр үе шатанд төслийн бүх зорилтот сургуулиудын дунд Туршлага солилцох хөтөлбөрийг зохион байгуулж, төслийн хүрээнд бий болсон сайн туршлага, сургамж болон цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэх боломж олгосон. Энэ нь сургууль хооронд хамтын ажиллагааг эхлүүлэх, бэхжүүлэх боломжийг хангаж өгсөн.

Төслийн үйл ажиллагааг түгээх зорилгоор зорилтот 3 дүүргийн зорилтот бус 35 сургуулийг хамруулсан түгээн дэлгэрүүлэх ажлын эхлэлтийн уулзалтыг хийсэн. Энэхүү уулзалтаас гадна, төслийн зорилтот сургуулиудаас зорилтот бус сургуулиудад зориулан төслийн үйл ажиллагааг дамжуулах, мэдээлэл түгээх сургалт, туршлага солилцох ажлуудыг зохион байгуулсан. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд төслийн үйл ажиллагааг зорилтот бус сургуулиудад нэвтрүүлэх, тэдгээр сургуулиудыг идэвхжүүлэх боломж бүрдсэн.

Мөн төслийн хүрээнд сургууль-эцэг эх хоорондын хамтын ажиллагаа бий болсон байна. Тухайлбал, “Сургууль-Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй” модулийн сургалтын үр дүнд, эцэг эхчүүд сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх аргачлалд суралцаж, түүнийг хичээлийн явцад ашиглан, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Эцэг эхийн зөвлөл нь дан ганц багштай бус үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх үед сургуулийн удирдлага болон бусад ажилтнуудтай болон бусад эцэг эхийн зөвлөлтэй хамтран

ажилладаг болжээ. Ялангуяа, сургалтын модульд өгөгдсөн хамтын ажиллагааг сайжруулах нарийвчилсан арга зүй нь багш-эцэг эх болон эцэг эх хооронд хамтран ажиллах, багаар ажиллах дадлыг бий болгоход эерэг хувь нэмэр оруулсан байна. Эдгээрээс гадна, эцэг эхийн зөвлөл хорооны эмч, цагдаа нартай хамтран хүүхдүүддээ сургалт зохион байгуулах, хүүхдийн явдаг замыг хороотой хамтран засах, хорооны Иргэний танхимыг ашиглан тэмцээн уралдаан зохион байгуулах, цагдаа нартай хамтран хөдөлгөөнт эргүүл хийх гэх мэт шинэ хамтын ажиллагааг бий болгожээ.

Төслийн хүрээнд бий болгосон эдгээр хамтын ажиллагаа нь нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварын талаар эцэг эх, багш, боловсролын мэргэжилтнүүд, шийдвэр гаргагчдын дунд нэгдсэн ойлголт бий болгож, хамтын санаачилга бүхий ажлуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн эерэг нөлөө үзүүлсэн. Мөн хамтрагч байгууллагуудын үйл ажиллагааг илүү уялдаа холбоотой, илүү зохион байгуулалттай болгож өгснөөрөө цаашдын хамтын ажиллагаа өргөжин тэлэхэд үнэтэй хувь нэмэр болсон байна.

4.5.3. Үр нөлөө

Эцсийн үнэлгээнд хамрагдсан багш нар хүүхдийн суралцах чадварын талаарх мэдлэг суурь модулийн сургалтын дараа 55.2 хувиар нэмэгджээ. Багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас дүгнэхэд сургалтын модулийн үр дүнд багш нар хүүхдийн дасан зохицох, суралцах чадварын талаарх ойлголт мэдлэгтэй болж, түүнийг сургалт болон сургалтын бус ажлаар дамжуулан практикт нэвтрүүлэх олон арга зүй, аргачлалыг сурсан байна. Мөн багш дан ганц сургалтын үйл ажиллагаанд анхаарах бус, эцэг эх, бусад ажилтнууд, сургуультай хамтран сургалтаас гадуурх ажлаар дамжуулан сурагчдын суралцах чадварыг хөгжүүлэх аргуудыг ашиглаж, заах явцдаа дадал болгосон. Эдгээр арга аргачлалыг багш нар дараагийн жилүүдэд хүүхдийн насны онцлогт тохируулан өөрчилж, баяжуулах замаар эерэг өөрчлөлтийг хадгалан үлдэх боломж бүрдсэн гэж үзэж байна. Мөн багш нарын 89.8 хувь нь хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хянах, ашиглах арга зүйг эзэмшсэн байна. Багш нарын 80-аас илүү хувь нь “Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах арга зүй” модуль сургалтын хүрээнд авсан мэдлэг, мэдээлэл, шинэлэг аргачлалыг өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Чанарын судалгааны үр дүнгээс харахад төслийн зорилтот сургуулиудын хамтын үйл ажиллагааны хүрээнд хороо, цэцэрлэг, өрхийн эмнэлэгтэй хамтран мэдээлэл солилцон бэлтгэл хөтөлбөрийн эцэг эхүүдтэй уулзах замаар хүүхдийн талаар илүү дэлгэрэнгүй судалгааг авч байна. Мөн багшийн ажлын төлөвлөгөөнд тусгагдан хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах хугацаа, давтамж, аргачлал, оролцогч талууд тодорхой болж хэлбэржин анги даасан багш нарын ажилд хэрэгжиж байна.

Сургуулийн бүтэц тогтолцооны хувьд төслийн зорилтот сургуулиудад “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр” болон бусад 4 модулиудын сургалтыг зохион байгуулсан. Уг сургуулийн хөтөлбөрийн хүрээнд сургуулийн зүгээс бага ангийн багш нар, багш бус сургуулийн ажилтнууд, эцэг эх, орон нутгийн хороо, эмнэлэг гэх мэт олон талуудтай хамтын ажиллагааг эхлүүлж, идэвхжүүлсэн. Эдгээрээс гадна, сургуулийн хөтөлбөр, жилийн төлөвлөгөө, сургуулийн дүрэм, журам болон багш, ажилтнуудын хөдөлмөрийн гэрээ болон ажлын байрны тодорхойлолтод нэгдүгээр ангийн сурагчдыг дэмжихтэй холбоотой зүйл, заалтуудыг тусгаж өгсөн. Энэ бүх шинэлэг, олон талыг хамарсан үйл ажиллагаа нь бүхий л талуудын дунд нэгдүгээр ангийн сурагчдын даасан зохицох болон суралцах чадварын талаар нэгдсэн ойлголт, мэдээлэлтэй болж, хамтарсан үйл ажиллагааны ач холбогдлыг ойлгоход эерэг нөлөө үзүүлсэн байна. Төслийн зорилтот 24 сургууль бүгд “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг

дэмжих сургуулийн хөтөлбөр”-г хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ орон нутгийн оролцогч талуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, хороо, орон нутгийн цэцэрлэг, өрхийн эмнэлэгүүдээс сурагчдын талаар мэдээлэл авах, хамтарсан сургалт, танилцах аяллыг зохион байгуулах, нэгдүгээр ангийн сурагчдад ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлд хамтран ажилладаг сайн туршлагуудыг бий болгожээ. Мөн сургуулийн зүгээс нэгдүгээр ангийн хүүхдийн дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд зориулсан үйл ажиллагааг багш, эцэг эхчүүдтэй хамтран төлөвлөж, зохион байгуулж, мэдээлэл солилцон ажиллаж байна.

Эцсийн үнэлгээний үр дүнгээс харахад эцэг эхчүүд хүүхдийн суралцах чадвар, хүүхдийн хөгжил болон хүүхдийн хөгжлийн талаар ойлголт, мэдээлэлтэй болжээ. Төслийн хүрээнд “Эцэг эх-Багштай харилцах дэвтэр”-тэй ажиллах арга зүй сургалтын модуль болон “Сургууль-Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй” сургалтын модулиудыг боловсруулж, эцэг эхчүүдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулсан. Зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн 92.4 хувь нь хүүхдийн сургуульд дасан зохицох болон суралцах чадварын талаар авсан мэдээлэл нь хэрэгцээ шаардлагад нь нийцсэн гэж хариулжээ. Сургалтаар эцэг эхчүүдийн хүүхдийн хичээлийг нас, сэтгэхүйн онцлогт нь таруулан давтуулах, бүлчингийн хөгжлийг нь дэмжих тоглоом хамт тоглох гэх мэт шинэ аргачлалыг эзэмшүүлсэнээр хүүхдийн суралцах чадварыг хөгжүүлэхэд эцэг эхийн оролцооны ач холбогдлыг ойлгуулсан. Үүнтэй холбоотойгоор багш болон эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулж буй сургалт, хурал гэх мэт олон төрлийн ажлууд дах эцэг эхчүүдийн оролцоо 90.7 хувь болж нэмэгдсэн байна. Энэ нь суурь судалгаатай харьцуулахад мэдэгдэхүйц өндөр үзүүлэлт юм. Мөн түүнчлэн, эцэг эхчүүд хичээлийн бэлтгэлд туслах, хүүхдүүддээ зориулсан хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх, анги, танхим тохижуулах гэх мэтээр багшийн үйл ажиллагааг нь дэмжиж ажиладаг дадал бий болсон. Багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас дүгнэхэд, эцэг эхчүүдийг хөгжлийн багуудад хувааснаар эцэг эхчүүдийн багаар ажиллах, хамтран ажиллах чадвар, идэвх сонирхол нэмэгдсэн. Энэ нь багш болон эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулж буй ажлууд дах эцэг эхийн оролцоо нэмэгдэж, бүтээлч хандлага бүхий ажлууд өргөжихөд эерэгээр нөлөөлсөн. Улмаар багш нарыг хүүхдийн суралцах чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн хичээл, сургалтын чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлэхэд хувь нэмэр болж байна. Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа нь хүүхдийн хөгжилд чиглэсэн ажлуудаар баяжиж, эцэг эх-хүүхэд-багшийн хамтын ажиллагааг нэмэгдэхэд хувь нэмэр оруулж байна. Сургуулийн зүгээс Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг сургуулийн төлөвлөлтөд оруулж, дэмжин ажилладаг болсон нь эцэг эх-багш-сургуулийн хамтын ажиллагаа тогтвортой, идэвхтэй явуулах үндсийг бүрдүүлж өгчээ. Үүнээс гадна бусад сургууль, эцэг эхийн зөвлөлтэй мэдээлэл солилцох, туршлага хуваалцах зэрэг жишиг арга хэмжээг зохион байгуулсанаар сайн туршлага түгэн дэлгэрэх боломж бүрдсэн байна.

Төслийн зорилт 4 буюу нөлөөллийн ажлын хүрээнд төсөл нь анх эхлэх үеэс хойш боловсролын салбарын стратегийн түвшинд ажиллаж буй гол талуудыг оруулсан Төслийн удирдах зөвлөлийг байгуулсан. Мөн төслийн зорилтот сургуулийн захирал, сургалтын менежер, багш нараас бүрдсэн 100 гаруй гишүүнтэй ажлын хэсгийг бүрдүүлэн ажилласан. Төслийн удирдах зөвлөл модулиудыг боловсруулах, сайн туршлага, үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, бусад сургууль оролцогч талуудад танилцуулах ажилд ихээхэн үүрэг рольтой оролцсон. Харин ажлын хэсэг нь зорилтот сургуулиуд дээр төслийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх, бусад сургуулиудад өөрсдийн мэдлэг, туршлагаа түгээн таниулах ажлууд болон ашиглаж буй модулиудад санал өгөх байдлаар ажилласан. Энэ бүх ажлын үр дүнд, төслийн өмнө төдийлөн тодорхой бус байсан сурагчдын дасан зохицох, суралцах чадварын талаар нэгдсэн ойлголт бий болж, үүнд чиглэсэн үйл ажиллагааг хамтран зохион байгуулах жишиг үйл ажиллагаанууд бий болсон. Яам, дүүрэг, сургуулийн түвшинд нягт хамтын ажиллагаа үүссэнээр төслийн хүрээнд боловсруулсан

сургалтын модулиуд болон жишиг үйл ажиллагааг цаашиг тогтвортой авч хэрэгжүүлэх орчин бүрдсэн.

4.5.4. Тогтвортой байдал

Төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах гол үндэс нь оролцогч талуудын оролцоо юм. Тиймээс төслийн хүрээнд сургагч багш нарыг бэлтгэх, мэдлэг, туршлагыг зорилтот бус сургуулиудад түгээх, хамтрагч талуудын хамтын ажиллагааг бий болгох, бэхжүүлэх ажлууд хийсэн.

Төслийн хүрээнд ашиглах сургалтын модулиудыг заах болон ашиглах багш нар, сургуулийн ажилтнууд болон эцэг эхчүүдийн дунд сургалт зохион байгуулсан. Ялангуяа төслийн үйл ажиллагаа, сургалтын арга зүйг хадгалан авч үлдэх зорилгоор сургагч багш нарыг бэлтгэж, 1-с 5-р ангийн багш нар, сургуулийн ажилтнуудыг хамруулсан олон тооны сургалтыг зохион байгуулжээ. Тухайлбал, 2015 онд нийт 376 сургагч багш, 1484 багш ажилтнуудыг хамруулсан сургалт зохион байгуулсан бол 2017 онд 206 сургагч багш, 1781 багш, ажилтнуудыг сургалтад хамруулсан байна. Энэ бүх сургалтын үйл ажиллагаа нь нэгдүгээр ангийн сурагчидтай ажиллах, тэдний суралцах болон дасан зохицох чадварыг хөгжүүлэх талаарх мэдлэг, чадвар, арга барил, туршлага уламжлан үлдэх гол хөшүүрэг болж байгаа юм.

Төслийн нэг онцлох үйл ажиллагаа нь зорилтот дүүргийн зорилтот бус 35 сургуулиудад чиглэсэн мэдлэг, аргачлал, сайн туршлага солилцох арга хэмжээ юм. Энэ нь төслийн үйл ажиллагааг төслийн зорилтот сургуулиудаас гадна дүүргийн болон нийслэлийн хэмжээнд мэдлэг, аргачлал, сайн туршлага түгэн дэлгэрэх боломжийг олгож байгаа юм. Уг мэдлэг, туршлага солилцох ажлын хүрээнд сургалтын модулиуд болон Эцэг эх-Багштай харилцах дэвтрийг зорилтот бус сургуулиудад тархаах ажил хийгдсэн.

Төслийн хүрээнд боловсруулсан сургалтын модулиуд нь маш сайн зааварчилгаатай, нарийвчилсан арга зүйн тайлбартай тул, нэгдүгээр ангийн багш нар төслийн үйл ажиллагаанд хамрагдаагүй ч, тодорхой ойлголт авах, аргачлалыг өөрсдийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломжтой байна. Гэхдээ уг 5 модуль нь өөр хоорондоо маш нарийн уялдаатай учраас цогцоор нь сургуулиудад нэвтрүүлэх шаардлагатай талаар багш нар ярилцлагын үеэр нийтлэг дурдаж байсан. Төслийн зорилтот сургуулиудад сургагч багш нар нэгэнт бэлтгэгдсэн тул, сургагч багш нараар дамжуулан модулиудын сургалтыг тогтмол зохион байгуулж, мэдлэг, ойлголтыг нь нэмэгдүүлэх, баталгаажуулах давтан сургалтуудыг гүйцэтгэх боломжтой. Улмаар эдгээр модулиудад заасан шинэлэг арга аргачлалыг шинэ багш нарт заан сургах, жил тутам шинэ аргачлалаар баяжуулах бүрэн боломжтой байна. Үүнээс гадна “Эцэг эх-багштай харилцах дэвтэр”-тай ажиллах арга зүй сургалтын модуль болон “Эцэг эх багштай харилцах дэвтэр”-т өгсөн дасгал тоглоом болон “Сургууль-Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй”-г цаашид хэрэгжүүлэх, хувирган өөрчилж 2-с 5-р ангид ангид хэрэгжүүлэх болох талаар багш нар дурдаж байлаа. Энэ нь төслийн үйл ажиллагаа зөвхөн нэгдүгээр ангиудад бус дараагийн анги, бүлгүүдэд ч тогтвортой авч хадгалж үлдэхүйц өөрчлөлт бий болгож байгааг харуулж байна.

Зорилтот сургуулиуд “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр” боловсруулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд багш нар, багш-бус ажилтнууд болон эцэг эхчүүд, орон нутгийн оролцогч талуудыг нэгдүгээр ангийн сурагчдыг дэмжихэд оролцуулах ажлуудыг зохион байгуулсан. Мөн сургуулийн хөтөлбөр, төлөвлөгөөнд бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг тусгаж, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, сургуулийн журам, дүрэмд нэгдүгээр ангийн сурагчдад дэмжлэг үзүүлэхтэй холбоотой нэмэлт өөрчлөлтүүдийг хийсэн. Эдгээр сургуулийн бүтэц тогтолцоо,

хөтөлбөрийн хүрээнд хийж буй өөрчлөлтүүд нь хөтөлбөрийн үйл ажиллагаа цаашид тогтмол хэрэгжих баталгаа болж байгаа юм.

Төслийн хүрээнд бий болгосон 100 орчим гишүүн бүхий Ажлын хэсэг болон Төслийн удирдах зөвлөлд орсон 12 байгууллагуудын дунд нягт хамтын ажиллагаа үүссэн. Ялангуяа энэхүү байгууллагуудын дунд дүүргийн болон үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулж буй талууд хамрагдсан нь төслийн амжилттай туршлага, сайн аргачлалыг бусад дүүрэг, орон нутгийн сургуулиудад нэвтрүүлэх боломж байгааг харуулж байна.

Мөн төслийн хүрээнд боловсруулсан сургалтын модуль, хөтөлбөр нь үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлж буй ажлуудын нэг хэсэг болсноор тогтвортой байдлаа хадгалах боломж бүрдсэн. Тухайлбал БСШУСЯ-ны сурах бичгийн нэгдсэн жагсаалтад “Бэлтгэл хөтөлбөр”-ийг оруулсан “Хүүхдийн хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах арга зүй” сургалтын модулийн зарим асуултуудыг Боловсролын Удирдлага мэдээллийн санд оруулсан зэрэг нь төслийн үйл ажиллагаа цаашид тогтвортой хадгалагдах болсныг харуулах онцлог жишээ юм.

Төсөл хэрэгжих хугацаанд төслийн гол бүтээгдэхүүнүүд болох сургалтын модулийг боловсруулсан, түүнийг заах сургагч багш нарыг бэлтгэсэн, сургууль тус бүрт “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр”-г боловсруулсан, оролцогч талууд хооронд хамтын ажиллагааг бүрдүүлсэн зэрэг нь төслийн үйл ажиллагаа хэрэгжих үндсэн нөхцөл бүрдсэн байгааг харуулж байна.

5. Дүгнэлт

Японы Хүүхдийг Ивээх Сангаас санаачлан хэрэгжүүлсэн энэхүү төсөл нь цагаа олсон, тун хэрэгцээтэй байсан, үр дүнтэй санаачлага байсан гэдгийг нэн тэргүүнд дурдах нь зүйтэй. Төслийн хүрээнд богино хугацаанд маш их ажлыг хийж амжуулсны зэрэгцээ хэрэгжүүлэхээр зорьсон зорилтдоо бүрэн хүрсэн байна. Төслийн үр дүнг хүртэгчид болох сурагчид, тэдэнд гарсан эерэг өөрчлөлтийн үр дүн нь урт хугацаанд гарах бөгөөд энэ нөлөөллийг бүрэн хэмжих дүгнэх боломж одоогоор байхгүй юм

Энэхүү төсөл “Төслийн зорилтот дүүргийн төрийн өмчийн сургуулиудын нэгдүгээр ангийн сурагчдын “суралцах чадвар”-ыг дээшлүүлэх” зорилгынхоо хүрээнд багш, сургууль, эцэг эхэд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээс гадна нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. Төслийн хүрээнд боловсруулсан 5 сургалтын модулийн хүрээнд нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг гэр бүлийн болон сургуулийн орчинд дээшлүүлэхэд эерэгээр нөлөөлөхүйц олон аргагүй, аргачлалыг нэвтрүүлж ажилласан. Үүний үр дүнд багш нарын суралцах чадварын талаарх ойлголт нэмэгдэхээс гадна, өөрсдийн сургалтын үйл ажиллагаанд олон шинэ арга, аргачлал, хэрэглэгдэхүүнийг нэвтрүүлж, ашиглаж байна. Мөн сургууль, ангийн орчныг нэгдүгээр ангийн сурагчдад ээлтэй байдлаар тохижуулж суралцах орчныг бүрдүүлсэн. Багш нар эдгээр туршлагаа бусад төсөл хэрэгжээгүй сургуулийн багш нартай солилцож, түгээж байна. Төслийн хүрээнд багш нар, эцэг эх, сургуулийн ажилтнууд болон хороо, цэцэрлэг, өрхийн эмнэлэг гэх мэт бусад талуудыг хамруулснаар тэд нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварын талаар нэгдсэн ойлголттой болсон. Улмаар нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дээшлүүлэхэд оролцогч тал бүрийн оролцоо тодорхой болж, хамтарсан жишиг ажлууд бий болж, тэдгээр сайн туршлагуудыг төсөл хэрэгжээгүй сургуулиудад түгээж байна. Эцэг эхийн мэдлэг, ойлголт нэмэгдэж, олон төрлийн шинэ аргачлалд суралцснаар сургуулийн болон гэр бүлийн орчинд хүүхдийн суралцах чадварыг дэмжих дадал, туршлага эзэмшиж байна. Мөн эцэг эхчүүд ЭЭЗ-өөр дамжуулан бусад бүлэг, сургуулийн эцэг эхчүүдтэй мэдлэг, туршлагаа солилцох туршлагатай болжээ. Төслийн үйл ажиллагааны үр дүн, сайн туршлагыг үндэсний хэмжээнд бага боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх үйл ажиллагааг БСШУСЯ болон нийслэл, дүүргийн боловсролын байгууллагуудын дэмжлэгтэйгээр нэвтрүүлэх, ажлыг гүйцэтгэжээ.

Эцсийн үнэлгээний үр дүнг төслийн зорилт тус бүрээр дараах хэсэгт дэлгэрүүлэн үзүүлээ.

5.1. Багш нар

- Багш нар сурагчдад зориулж танилцах аялал хийх, ангид таатай орчин бүрдүүлэх, эцэг эхтэй нь хамтран хэрэглэгдэхүүн бэлтгэх, хичээл заах гэх мэт дасан зохицох чадварт чиглэсэн шинэ арга зүй ашиглаж эхлэсэн нь сургалтын явцад үүсдэг бэрхшээлүүдийг багасгасан. Ялангуяа эцэг эхтэй хамтран ажиллаж буй арга зүй нь багш нарын ачааллыг бууруулсанаар сургалтын агуулгад анхаарч, хүүхэд тус бүрийн суралцах чадварыг сайжруулахад эерэг нөлөө үзүүлж байна.
- Модуль сургалтуудад зөвхөн багш бус, сургуулийн удирдлага болон бусад ажилтнуудыг хамруулж байгаа нь сургуулийн орчинд нэгдүгээр ангийн сурагчид болон багш нарт дэмжлэг үзүүлдэг хандлага, дадлыг бий болгож өгч байна. Энэ нь сургуулийг хүүхдийн дасан зохицох чадвар, суралцах чадварыг дэмжсэн таатай орчин болоход эерэг хувь нэмэр оруулж байна. Гэхдээ сургуулийн удирдлагын хандлага болон тогтвортой байдлаас хамааран үр өгөөж нь харилцан адилгүй байгааг анхаарах хэрэгтэй.
- Хүүхдийн хувийн мэдээлэл цуглуулах, сурагчдийн хөгжил, чадварын түвшин, түүний ахицыг үнэлэх, судалгаанд суурилан сургуульд дасан зохицох үйл явцыг удирдах үйл ажиллагаа зорилтот сургуулиудад сайн хэрэгжин үр дүнд хүрч байгаа ч багшийн ажлын ачаалал их,

анги дүүргэлт олон, урамшуулал бага, мэдээллийг боловсруулах туршлага дутмаг байдлууд бэрхшээл үүсгэж байна.

- “Хүүхдийн хувийн мэдээлэл цуглуулж, ашиглах арга зүй” модуль сургалтын агуулга, аргачлал, үр өгөөжийг багш нар эерэгээр үнэлж байна. Сургалтын үр дүнд хүүхдийн хувийн мэдээллийн сан бүрдүүлэх чадвартай болж, мэдээллийн сангаа ашиглах хандлагатай болжээ.
- Багш нарын дийлэнх нь хүүхдийн хувийн мэдээллийн санг үүсгэж ашигладаг болсон байна. Хүүхдийн онцлогт тохируулан сургалтаа явуулахдаа хувийн мэдээллийг ашигладаг болсон багш нарын хамрах хүрээ нь өргөжсөн ч гүнзгийрэлт хангалттай биш байна. Дээрх мэдээллийг бүрэн ашиглаж байгаа хувь хангалттай өндөр биш байна. Бүрэн ашиглахын зэрэгцээ, үр дүнтэйгээр ашиглах тал дээр анхаарах хэрэгтэй
- Төсөл өргөн хүрээтэй, үр дүнтэй олон ажлуудыг санаачилж, хэрэгжүүлж байгаа нь багш эцэг эхчүүдийн дэмжлэгийг авч үр дүнд хүрч байгаа ч багшид тодорхой хэмжээний ачааллыг үүсгэж байна. Анги дүүргэлт их, багшийн ажлын ачаалал угаасаа өндөр, урамшуулал багатай байгаа нь төслийн үр дүнг нэмэгдүүлэхэд бэрхшээл үүсгэж байна.
- Төслийн үр дүнд бий болсон бас нэг сайн туршлага нь, бага ангийн багш нар болон СӨБ-ийн багш нарын хамтарч ажиллах болсон явдал юм. Ялангуяа хүүхдийн хувийн мэдээллийн санг бүрдүүлэх, хүүхдийн хувийн онцлогийн талаар мэдэхэд нь бага ангийн багш нарт ихээхэн дэмжлэг үзүүлдэг байна.
- СӨБ-д хамрагдсан болон хамрагдаагүй хүүхдүүдийн суралцах чадвар, сургуульд дасан зохицох байдалд ялгаа байсаар л байна. Энэ ялгаа нь сургалтад ихээхэн хүндрэл учруулах магадлалтай юм.

5.2. Сургуулийн дэмжих бүтэц тогтолцоо

- Зорилтот сургуулиудад нэгдүгээр ангийн хүүхдийг сургуульд дасан зохицох суралцах чадварыг дэмжих бодлогыг бий болгох зорилгоор сургуулийн бодлогын баримт бичгүүд, дотоод журамдаа өөрчлөлтүүдийг оруулан бодлого эрх зүйн орчин бүрдсэн нь төслийн аргачлал, арга зүйг сургуулиудад тогтвортой хэрэгжүүлэх боломж бүрдсэн байна.
- 2015 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад судалгаанд оролцогч багш нар хүүхдийг сургуульд хүлээн авах үйл ажиллагаанд сургуулийн удирдлага, менежерүүд дэмжин ажиллах ажиллаж ажиллаж ахиц гарсан гэж үнэлж байна.
- Сургуулийн гадна болон дотоод орчинд үнэлгээ хийн сургалтын орчныг сайжруулах, сургуулийн анги танхимын тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах, сургалтын орчны зураглал гаргах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн нь эрүүл, аюулгүй орчинд суралцах нөхцөлийг сайжруулсан байна.
- Багш нар, удирдлагууд нэгдүгээр ангийн сурагчийг сургуульд дасан зохицуулах талаар ойлголт, мэдлэгтэй болж, багш нарын хандлага ихээр өөрчлөгдсөн ба сургалтын менежер, 1-р ангийн секцийн ахлагч нар дотоод сургалтуудыг голлон зохион байгуулж, удирдлага, зохион байгуулалтаар ханган сургуульдаа хамтын ажиллагаа сайжирсан байна.
- Сургуулийн ажилтнууд болох номын санч, эмч, бусад ажилтнууд бага ангийн багшийг дэмжин, 1-р ангийн хүүхдийн хөгжилд төлөвшилд мэргэжлийн болон сургуулийн ажилтны хувьд хамтран ажиллаж, нээлттэй эерэг хандлагаар харилцан нийгэм сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэн ажиллаж байна.
- Багш нар сургалтын материаллаг орчин бүрдүүлэх чиглэлээр анги бүр сургалтын хэрэглэгдэхүүн, үзүүлэн, тараах материал, сурагчдын бүтээл, мэдээллийн самбаруудыг хийн ажиллаж байна.

- Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд бэлтгэгдсэн байдал, дасан зохицох чадварыг дэмжих чиглэлээр сургуулийн хамтран сургах тойргийн цэцэрлэг, хороо, өрхийн эмнэлэгтэй дараах байдлаар хамтран ажилласан байна.
- 1-р ангийн хүүхдийн сургуульд дасан зохицох чадварыг дэмжих сургуулийн тогтолцоог бүрдүүлэхэд орон нутгийн байгууллагуудын хамтын үйл ажиллагаа, оролцогч талуудын идэвх оролцоо харилцан адилгүй байна.

5.3. Эцэг эхчүүд

- Төслийн хүрээнд эцэг эхчүүдэд чиглэсэн үйл ажиллагааны үр дүнг эцэг эхчүүдийн багштай мэдээлэл солилцож буй байдал болон эцэг эхчүүдийн зөвлөлийн үйл ажиллагааны идэвхтэй үйл ажиллагаа, түүнийг түгээн дэлгэрүүлж буй байдлаар хэмжсэн. Эцсийн судалгааны үр дүнгээс харахад, нийт эцэг эхчүүдийн 90.7 хувь нь сургалт, харилцах дэвтрээр мэдээлэл солилцох гэх мэт олон төрлийн хэлбэрээр багштай мэдээлэл солилцож, хамтран ажиллаж байна. Ялангуяа, төслийн хүрээнд боловсруулсан “Эцэг эх-Багштай харилцах дэвтр”-тэй ажиллах арга зүй сургалтын модульд заасан багштай харилцах, хамтран ажиллах үйл ажиллагаанууд дах эцэг эхчүүдийн хамтын ажиллагаа, оролцоо өндөр байна.
- Төслийн хүрээнд боловсруулсан сургалтын модулиуд, гарын авлагууд, танилцуулгууд, багш нарыг бэлтгэх сургалтууд, зуны сургалт, эцэг эхийн зөвлөлтэй ажиллах аргачлал зэрэг нь бүгдээрээ багш эцэг эхчүүдийн хэрэгцээнд нийцсэн, шинэлэг ажил болж чадсан байна.
- Эцэг эхчүүдэд зориулсан модулийн сургалтуудыг зохион байгуулснаар эцэг эхчүүдийн хүүхдийн суралцах чадварын талаарх ойлголт сайжирч улмаар шинэлэг арга зүй, аргачлал, хэрэглэгдэхүүн бэлтгэх, анги танхим тохижуулахад эцэг эхийн оролцоо нэмэгджээ. Тухайлбал, эцэг эхчүүдийн сонирхол хөгжүүлэх багуудад хуваарилж, багаар ажиллуулах ‘Баруун гарын баталгаа’, ‘Манай гэр бүл’, ‘Би ирлээ’ гэх мэт самбарууд ажиллуулах гэх мэт ажлуудыг хийснээр эцэг эх-багш хоорондын хамтын ажиллагаа сайжирч, тогтмолжсон байна.
- Мөн төслийн зорилтот сургуулийн эцэг эхийн оролцоо нь зорилт бус сургуулийн эцэг эхээс илүү их оролцоотой байгаа нь төслийн эерэг үр нөлөөг тодруулан харуулж байна. Эцэг эхийн оролцоо нь гэр, анги, сургуулийн орчинд хүүхдийн засан зохицох, суралцах чадварыг хөгжүүлэх боломжийг олгохоос гадна, багш нарын сургалтын чанар, хэрэглэгдэхүүний хүртээмж зэрэг маш олон түвшинд эерэг өөрчлөлт бий болгосон байна. Төслийн хүрээнд зорилтот сургуулиудын эдгээр түршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 3 дүүргийн зорилтот бус 34 сургуулийг хамруулсан түгээн дэлгэрүүлэх ажлын эхлэлтийн уулзалтыг хийсэн. Энэхүү уулзалт нь сургууль хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, зорилтот сургуулиудыг бусад дүүрэг, аймагт амжилттай түршлагыг түгээн дэлгэрүүлэх түршлагатай болгож өгсөн. Гэхдээ, төслийн үр дүн өгөөж, ажиллах сайн түршлагыг төсөл хэрэгжээгүй бусад сургуулиудад түгээн дэлгэрүүлэх ажил төдийлөн хүрэлцээтэй, далайцтай болж чадаагүй байна.
- Төслийн үр дүнд төслийн зорилтот 24 сургуульд Эцэг эхийн зөвлөлийг байгуулагдсан байна. Төслийн хүрээнд “Сургууль-Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй” сургалтын модулийг боловсруулсан. Зорилтот сургуулиуд уг сургалтын модулийг ашигласнаар эцэг эхийн зөвлөл үйл ажиллагаандаа шинэ аргачлал, арга зүйг нэвтрүүлж, үйл ажиллагааг нь илүү зохион байгуулалттай болгох, шинэ төрлийн үйл ажиллагаа санаачлан хэрэгжүүлэх бүрдсэн. Судалгаанд хамрагдсан зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн 94.0 хувь нь сургуулийнхаа ЭЭЗ-г мэдэж байгаа бөгөөд үйл ажиллагаанд нь оролцож байжээ. Мөн олонхи (80.4%) нь ‘Сургууль-Багш-Эцэг Эх’-н хамтын ажиллагаа эерэг (маш сайн, сайн) үнэлгээ өгсөн байна. Дээрх тоон үзүүлэлтүүд нь төслийн үр дүнд эцэг эхийн оролцоо сайжирсан байгааг харуулж байна. Мөн эцэг эхийн оролцоо сайжирч, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг болсноор багш нарын ачаалал багасч, хүүхдэд ээлтэй анги танхим, орчин бүрдүүлэх,

шинэлэг сургалтын аргачлал, хэрэглэгдэхүүн ашиглах зэргээр хүүхдийн суралцах чадварыг дээшлүүлэх боломж бүрдэж байгааг чанарын судалгааны үр дүн харуулж байлаа.

- Эцэг эхийн зөвлөл байгуулагдаад үр дүнтэй ажилладаг болсон бол энэ эрч нь цаашид ч хадгалагддаг байна. Нэгдүгээр энгийн эцэг эхчүүдийн зөвлөл идэвхтэй ажиллахаас гадна өнгөрсөн жилүүдэд байгуулагдсан эцэг эхийн зөвлөлүүд хүүхдүүд нь 2, 3- р ангид орсон ч үйл ажиллагаагаа идэвхтэй хадгалж, хоорондоо өрсөлдөж, хамтарч ажилласаар байгаа аж.
- СӨБ-д хамрагдаагүй хүүхдүүдийн эцэг эхчүүд болон багш нарын харилцан мэдээлэл солилцох хамтран ажиллах байдалд ахиц гарч, эцэг эхчүүд идэвхжсэн байна. Төсөл хэрэгжээгүй сургуулиудтай харьцуулбал төсөл хэрэгжсэн сургуулиудын эцэг эхчүүдийн багш нартай ажиллах, мэдээлэл авах байдалд мэдэгдэхүйц нэмэгджээ.
- Эцэг эхчүүд, харилцах дэвтрийг “тодорхой хэмжээнд” ашигладаг, харилцах дэвтэр үр өгөөжтэй гэж үнэлж байгаа ч харилцах дэвтрийн ашиглалт хангалттай биш байна. Цаашид харилцах дэвтрийн ашиглалтыг улам сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

5.4. Нөлөөлөл

- Төсөл хэрэгжиж эхлэмэгц 2015 оны 6 сард БСШУСЯ-тай Харилцан ойлголцлын санамж бичиг зурсан. Мөн төслийн бодлогын түвшинд арга зүйгээр хангах, боловсролын салбарын гол оролцогч талуудын дунд нягт хамтын ажиллагааг бий болгох зорилго бүхий Төслийн Удирдах Зөвлөлийг байгуулсан. Дээрх байгууллагуудаас нийт 6 байгууллага нь төсөлтэй идэвхтэй хамтран ажилласан байна. Тухайлбал, БСШУСЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын багш, сургагч, зөвлөхүүдтэй хамтран сургалтын модулиудыг боловсруулсан. Боловсруулсан сургалтын модулиуд дээр БСШУСЯ, дүүрэг, нийслэлийн боловсролын мэргэжилтнүүдээс санал авч сайжруулан эцэслэсэн. Мөн жил тутам сургууль болон оролцогч талуудын саналын дагуу сайжруулах ажлыг жил тутам зохион байгуулсан.
- Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд БСШУСЯ-ны сүрах бичгийн нэгдсэн жагсаалтад “Бэлтгэл хөтөлбөр”-ийг оруулсан “Хүүхдийн хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах арга зүй” сургалтын модулийн зарим асуултуудыг Боловсролын Удирдлага мэдээллийн санд оруулсан ололттой байна. Энэ нь төслийн хүрээнд хийгдсэн нөлөөллийн ажлын амжилттай жишээ болж байна. Ингэснээр, энэ бэлтгэл хөтөлбөр нь үндэсний хэмжээнд хэрэгжих өргөн далайцтай, цаашид тогтвортой хэрэгжих үлдэцтэй ажил болж чаджээ.
- Эдгээрээс гадна төслийн зорилтот сургуулиудын захирал, сургалтын менежер, багш нараас бүрдсэн ажлын хэсэг байгуулагдаж ажилласан бөгөөд төслийн хэрэгжилтийн явцад тогтмол үүлзалт хийж мэдээлэл, түршлага солилцох ажлуудыг зохион байгуулсан. Энэхүү ажлын хэсгийн ажлын үр дүнд төслийн арга аргачлал, сайн түршлагыг эцэг эх, багш нарын оролцоотойгоор зорилтот бус сургуулиудад түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан. Дээрх оролцогч талуудын хамтын ажиллагаа, тэдгээрийн үр дүн нь төслийн үйл ажиллагааг зорилтот бус сургууль, дүүрэг болон нийслэл, улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, цаашид тогтвортой хадгалан авч үлдэхэд эерэг нөлөөтэй байсныг харуулж байна.

6. Санал зөвлөмжүүд

Судалгааны үр дүн, дүгнэлтэд үндэслэн санал зөвлөмжийг боловсруулахдаа дараах зүйлсийг анхаарсан болно.

- Багш болон багш бус ажилтан, сургуулийн удирдлага, эцэг эх, асран хамгаалагч нар нь хүүхдийн суралцах чадварыг хангахад хамгийн их шууд нөлөөлөх, ойрын субъект учраас голлон авч үзсэн ба салбарын яам, мэргэжлийн байгууллагаас анхаарах, тэдгээрт чиглэсэн санал зөвлөмжийг тусгайлан гаргасан болно.
- Хүүхдийн суралцах чадварыг хангах талаар зорьж байгаа сургуулийн бага ангийн багш нар, сургуулийн удирдлага өөрсдөө багшлахуй болон суралцахуйн мэдлэг чадвараа хөгжүүлэх ба багш нарт дэмжигч талуудын ажлын үялдаа, төлөвлөлт, бодлогыг хөгжүүлэхтэй холбоотой санал зөвлөмж,
- Нэгдүгээр ангийн хүүхдийн суралцах чадварыг дэмжих ялангуяа сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдэд сургуульд дасан зохицох, суралцах чадвар эзэмшихэд туслах бүтэц, тогтолцоог сайжруулахтай холбоотой санал зөвлөмж,
- Эцэг эхчүүд хүүхдийн суралцах чадварыг дэмжихэд шаардлагатай үйл ажиллагаа, сургалт, сурталчилгааны ажил, мөн тэднийг дэмжигч талуудын ажлын үялдаа, тогтолцоог сайжруулахтай холбоотой санал зөвлөмжүүдийг тус тус боловсрууллаа.

6.1. Багш

- Багш нар төслийн модуль сургалтын агуулгыг бүрэн эзэмшиж, мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үр дүнг эргэцүүлэх, дүн шинжилгээ хийх, сайжруулах, нэвтрүүлэх, түгээх гэсэн бүтээлч, цогц нэгдмэл байдалд төвлөрөн ажиллах
- Хичээлийн жилийн эхэнд болон төгсгөлд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан болон хамрагдаагүй хүүхдийн дунд ялгаа бий эсэх, ялгаа хэр арилж байгааг илрүүлэх, үр дүнг нэгтгэж дүүрэг, нийслэл, улсын түвшинд дүн шинжилгээ хийх боломжийг судлах, ажлыг эхлүүлэх
- Хувийн мэдээллийг бодитой цуглуулах, мэдээллийг бүрэн ашиглаж байгаа багшийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, цэцэрлэгт яваагүй хүүхдийн мэдээллийг эцэг эхээс авахын өмнө эцэг эхэд мэдээллийн ач холбогдол, үнэ цэнийг талаар ойлгуулах, багш эцэг эхийн хамтын ажиллагааны эхлэл болохыг таниулж мэдрүүлэх
- Багш, ажилчдын тогтвортой бус байдлаас хамааран харилцан адилгүй мэдээлэл авч байна. Тиймээс, жил тутмын эхэнд хийж буй модулиудын сургалтыг давтан хийх, баримтжуулж, бичлэг хийж, шинээр орж буй багш нарт мэдлэгийг ижил түвшинд хүргэх
- Сургуульд бэлтгэгдсэн байдал, сургуульд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхэд цэцэрлэг сургуулийн хамтын ажиллагаа, бүх талын залгамж холбоо чухал үүрэгтэй тул хичээлийн жилд уламжлал болгосон ажлыг дүүрэг, нийслэл, улсын хэмжээнд хийдэг болох

6.2. Сургуулийн удирдлага

- Зорилтот сургуулиудын хамран сургах тойргийн орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд хамтын ажиллагааны харилцан ашигтай нөхцөлүүдийг санаачлах, байгууллагуудын удирдлагуудад нөлөөллийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай байна.
- Сургуулийн удирдлага болон бусад ажилтнуудын зүгээс нэгдүгээр ангийн багш нар болон сурагчдад дэмжлэг үзүүлж буй бүтэц, тогтолцоо, түүний үр дүнг бусад сургуулиудад таниулах, сурталчлах үйл ажиллагаа явуулах. Жишээлбэл, сайн туршлага бүхий сургуулиудад баримтат кино, бичлэг хийн, яамны болон бусад байгууллагын гол вэб

сайтуудад байршуулж, хичээлийн жилийн турш олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сайн туршлага түгээх

- Сургуулийн менежер, багш, ажилтнуудын тогтвор суурьшилгүй байдлаас шалтгаалан төслийн хүрээнд хэрэгжсэн багш нарын чадавхижуулах сургалтуудын үр дүнд нөлөөлж байгаа тул боловсролын салбарын хүний нөөцийн бодлогод БСШУСЯ, Нийслэл, Дүүргийн Боловсролын Хэлтэс, ЕБС-ийн удирдлага анхаарах шаардлагатай байна.
- Шинэ болон өмнө бэлтгэсэн сургагч багшийг тасралтгүй бэлтгэх, сургуулиудын сургагч багшийн туршлага солилцох, хамтран ажиллах ажлын төлөвлөлт хийх, сургагч багш нар багаараа судалгааны ажил хийх
- Улаанбаатар хотын алслагдсан дүүргийн онцлогоос хамаарч сургуулиудын дотоод гадна орчны үнэлгээнд агаарын бохирдол, дуу чимээ, тоосжилт, зам тээврийн осол зэрэг орчны оюулгүй байдалтай холбоотой үзүүлэлтүүдийг тусгасан эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.
- Сургуулийн санхүүжилт, төсөв хөрөнгөний хомс байдлаас төслийн хэрэгжилтийн хугацаанд амжилттай үр дүн үзүүлж байсан үйл ажиллагаанууд цаашид зогсонги байдалд орох магадлал өндөр байна. Ийм учраас ЕБС-ийн интернэт орчинг сайжруулах, төслийн 5 модуль сургалтын гарын авлага, эцэг эхтэй харилцах дэвтэр, дасгал ажлын дэвтэр зэргийг цахим хэлбэрээр байршуулах, сурталчлах замаар цаасан, өртөг өндөр технологиос татгалзан шийдлийг хийх, цаашид тогтвортой ашиглах асуудлыг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсруулж, хэрэгжүүлэхэд боловсролын болон санхүүгийн төрийн захиргааны байгууллагын дэмжлэг шаардлагатай байна.
